

МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

ЗАХИАЛАГЧ:
МОНГОЛБАНК

ГҮЙЦЭТГЭГЧ:
Э.ЭРДЭНЭЦЭЦЭГ

2020 он

АГУУЛГА

ОРШИЛ

Нэг. Барьцаалан зээлдүүлэх болон иргэд хоорондын зээлийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт

1. Зохицуулах хуулиуд
2. Бүртгэл, тавигдах шаардлага
3. Хувь хүн, хуулийн этгээд мөнгөн зээлийн үйл ажиллагааг эрхэлж болох эсэх
4. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчид тавигдах шаардлага (хувьцаа эзэмшигч, хувь хүнд тавигдах хягаарлалт)
5. Арга хэмжээ (сануулга, түдгэлзүүлэх, хүчингүй болгох тохиолдол)
6. Зээлийн хүүгийн дээд хэмжээ тогтоосон эсэх
7. Барьцаа, үнэлгээ
8. Бүртгэлтэй этгээдийн үүрэг
9. Бүртгэлгүй этгээдийн хариуцлага
10. Бүртгэлтэй этгээдийн хариуцлага

Хоёр.Өдрийн зээл

Гурав. Санал, дүгнэлт

ОРШИЛ

Монгол Улсын хэмжээнд 1000 орчим барьцаалан зээлдүүлэх газар үйл ажиллагаа явуулж байгаа ба үүнээс 872 нь нийслэл хотод үйл ажиллагаагаа явуулж байна. Тэдгээрээс 1 эзэнтэй боловч 30-40 салбартай барьцаалан зээлдүүлэх газар цөөнгүй байна. Тухайлбал, Начин заан, Сайн ломбард гэх мэт.

Иргэний хуулийн 286 дугаар зүйлийн Барьцаалан зээлдэх журмаар зээл олгох зохицуулалт болон Монгол Улсын стандарт MIS:5274-2017 “Барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаанд тавих стандарт”-ын дагуу тус үйл ажиллагааг зохицуулж ирсэн байна.

Одоогийн байдлаар Барьцаалан зээлдэх үйл ажиллагааг явуулах хуулийн этгээд нь харьяа дүүргийн нэгж болон цагдаагийн байгууллагатай гурван талт гэрээ байгуулан үйл ажиллагаа явуулдаг, төдийгүй хэрэгжилтийг Цагдаагийн байгууллагын Хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх тасгийн 1 албан хаагч хариуцан ажилладаг.

Барьцаалан зээлдэх үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо, нэгдсэн бүртгэл тодорхойгүй, үүний улмаас нийт зээлийн хэмжээ, бичил санхүүгийн зах зээл дэх мөнгөн эргэлтийг бодитой тогтоох боломжгүй байна.

Түүнчлэн ломбардууд зээлийн хүүг дураараа нэмэгдүүлэх, өндөр түвшинд барих, анз, алданги тооцох, иргэдэд цөөн хоногийн хугацаатай зээл өгч мөнгө хүүлэх, иргэдийн барьцааны эд зүйлийн үнэлгээг багаар тогтоох, барьцааг зарж борлуулсан бол зөрүү мөнгийг буцаан олгохгүй байх, хулгайн гэмт хэргийн тоо нэмэгдэхэд шууд бусаар нөлөөлөх зэргээр иргэдийн эрх ашгийг ноцтой зөрчсөөр байна.

Цагдаагийн ерөнхий газрын мэдээллээс харахад, Монгол Улсын хэмжээнд **1000** орчим барьцаалан зээлдүүлэх газар үйл ажиллагаа явуулж байгаа ба үүнээс 872 нь нийслэл хотод үйл ажиллагаагаа явуулж байна. Тэдгээрээс 1 эзэнтэй боловч 30-40 салбартай барьцаалан зээлдүүлэх газар цөөнгүй байна.

Харин Татварын ерөнхий газраас ирүүлсэн мэдээллээс үзвэл, Барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгжээс 2020 оны 02 дугаар сарын байдлаар **294** татвар төлөгчийн **33.5** тэрбум борлуулалтын орлогоос **2.5** тэрбум төгрөгийн татвар төлсөн байгаа боловч эдгээр аж ахуй нэгжийн үйл ажиллагааны чиглэлийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын <http://opendata.burtgel.gov.mn/> сайтаас үзэхэд, 1 аж ахуй нэгж барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаанаас гадна гурваас доошгүй өөр үйл ажиллагаа эрхэлдэг, мөн 1 аж ахуй нэгж 10 гаруй үйл ажиллагаа эрхлэхээр бүртгүүлсэн тохиолдол цөөнгүй байна. Тухайлбал, барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаанаас гадна амралтын газар, барилга, барилгын материал, газар тариалан, фермер, зуучлал, цайны газар, зочид буудал, дэлгүүр, автомашины худалдаа, сургалт, үсчин, гоо сайхан, спиртийн үйлдвэрлэл зэрэг салбарын үйл ажиллагаа давхар эрхлэх нь түгээмэл байна.

Иймээс эдгээр 294 аж ахуй нэгжийн зөвхөн барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаанаас олсон орлого, түүнд төлсөн татварыг тодорхойлох боломжгүй байдалтай байна.

Үр дүнд нь барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо, нэгдсэн бүртгэл тодорхойгүй, 1000 орчим аж ахуй нэгжээс 294 нь татвар төлсөн гэж буй

боловч зөвхөн зээлийн үйл ажиллагаанаас олсон орлого, тус орлогоос төлсөн татварыг ялгаж тодорхойлох боломжгүй, түүнчлэн ЦЕГ-ын мэдээлэлд дурдагдсан 1000 орчим барьцаалан зээлдүүлэх газраас үлдсэн 600 гаруй аж ахуй нэгж огт татвар төлөөгүй байдалтай байх бөгөөд үүний улмаас нийт зээлийн хэмжээ, бичил санхүүгийн зах зээл дэх мөнгөн эргэлт, татвар төлөлтийг бодитой тогтоох боломжгүй байна.

Харин иргэд хоорондын зээлийн үйл ажиллагааны хувьд нэгдсэн бүртгэл хяналт, стандарт байхгүй, улсын төсөвт тус зээлийн үйл ажиллагаанаас олсон орлогын албан татвар төлсөн тохиолдол байхгүй, хэт өндөр хүү тогтоож анз, алданги авч, зарим тохиолдолд зээлдэгчийн үл хөдлөх хөрөнгийг барьцаалж зээл олгож байгаа болно.

Тухайлбал, Эрхийн улсын бүртгэлд бүртгэгдсэн нийт үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээний мэдээллээс харахад 2020 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар 23,983 үл хөдлөх хөрөнгө барьцаалагч иргэн 56,996 үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээ байгуулсан байгаа нь үүний цаана эдгээр санхүүгийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлгүй компаниуд тогтмол, ашиг олох зорилгоор иргэдийн үл хөдлөх хөрөнгийн барьцаалан өндөр хүүтэй зээлийн үйл ажиллагаа явуулж байгааг харуулж байна гэж үзэж байна.

Эдгээрээс дүгнэн үзэхэд, Монгол Улсын хэмжээнд Банк, Банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоог бүртгүүлж, хяналт тавьж ажиллаж байхад хувь хүмүүс хоорондын зээл, барьцаалан зээлдүүлэх газрын зээлд хичнээн хэмжээний бэлэн мөнгөний эргэлт байгаа, ямар хэмжээний хүү тогтоодог, түүнд тавигдах шаардлага байхгүйгээс татвар төлөлт байхгүй, тэдгээрээс зээл авч буй этгээдийн эрх буюу санхүүгийн хэрэглэгчдийн эрх ашиг зөрчигдөхөд хүрч байна.

Түүнчлэн 2020 оны 08 дугаар сарын 03-ны байдлаар зээлийн гэрээнээс үүдэлтэйгээр гарсан залилангийн хэргийн тоо 2010 оноос 2020 оны эхний 7 сарын хугацаанд 1700 орчим байна. Үүнээс 2014 оноос эрс нэмэгдэж жилд дундажаар 300-аад зээлийн гэрээнээс үүдэлтэй залилангийн хэрэг гарч байна.¹ Өөрөөр хэлбэл, иргэд ашгийн төлөө, тогтмол зээлийн үйл ажиллагаа явуулснаараа өөрсдөө мөн гэмт хэргийн хохирогч болох тохиолдол түгээмэл болсон байна.

Дэлхийн улс орнууд эдгээр асуудлыг хуулиар зохицуулж, Банк, ББСБ, ХЗХ-оос бусад мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчийг ашгийн төлөө, тогтмол тус үйл ажиллагаа эрхлэгчээр бүртгэн хянаж, үйл ажиллагааны тогтсон стандарт нэгэнт бий болжээ.

Иймд гадаад улсуудын иргэд хоорондын зээлийн үйл ажиллагаа болон барьцаалан зээлдүүлэх газрын эрх зүйн зохицуулалтын жишиг болсон нийтлэг зохицуулалтуудыг судалж, Монгол Улс дахь мөнгөн зээлийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох тодорхой санал дэвшүүлэх зорилгоор энэхүү судалгааг хийж гүйцэтгэлээ.

¹ ЦЕГ-ын статистик мэдээллээс.

НЭГ.БАРЬЦААЛАН ЗЭЭЛДҮҮЛЭХ БОЛОН ИРГЭД ХООРОНДЫН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1.БАРЬЦААЛАН ЗЭЭЛДЭХ ЖУРМААР ЗЭЭЛ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН ИРГЭД ХООРОНДЫН АШИГ ОЛОХ ЗОРИЛГООР, ТОГТМОЛ ЗЭЭЛ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Дэлхийн улс орнууд Иргэний хууль, Худалдааны хууль, Хэрэглэгчийн зээлийн үйл ажиллагааны тухай хуулиараа эсвэл бие даасан тусдаа хуулиар барьцаалан зээлдүүлэх болон иргэд хоорондын мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулж байна.

Монгол Улсын хувьд барьцаалан зээлдэх журмаар зээл олгох үйл ажиллагааг Иргэний хуулийн 286 дугаар зүйлийн Барьцаалан зээлдэх журмаар зээл олгох зохицуулалт болон Монгол Улсын стандарт МИС:5274-2017 “Барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаанд тавих стандарт”-ын дагуу тус үйл ажиллагааг зохицуулж ирсэн байна. Иргэний хуулийн 451-453 дугаар зүйлд заасан Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох зохицуулалтыг ерөнхий зээлийн гэрээний зохицуулалтаас тусад нь зохицуулсан боловч Барьцаалан зээлдүүлэх журмаар зээл олгох үйл ажиллагааг зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд гэдэгт оруулаагүй буюу ерөнхий зээлийн гэрээний нэг тусгай зохицуулалт болгон хуульчилснаас барьцаалан зээлдүүлэх журмаар зээл олгох үйл ажиллагааны нэгдсэн бүртгэл байхгүй, үүнээс улбаалан үйл ажиллагаанд нь хяналт тавьж чадахгүй байдалд орсон.

Иргэд хоорондын зээлийн үйл ажиллагааны хувьд тогтмол, ашиг олох зорилгоор зээлийн үйл ажиллагааг иргэд олгохын сацуу банк, ББСБ, ХЗХ-ны аль нь ч биш хуулийн этгээд өндөр хүүтэй олгож, үүнээс гадна анз, алданги өндөр хэмжээнд авч, шүүхээр энэ төрлийн хэрэг маргаан шийдвэрлэлт маш түгээмэл байна.

2019 оны байдлаар иргэний хэргийн шүүхийн нийт шийдвэрлэсэн хэргийн **25 хувь** нь Иргэний хуулийн 281-286 дугаар зүйлд заасан иргэд хоорондын болон барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагааны зээлийн гэрээний маргаан байна. Харин банк, ББСБ-аас олгох зээлтэй холбоотой маргаан иргэний хэргийн шүүхийн нийт шийдвэрлэсэн хэргийн **14 хувийг** эзэлж байна.²

Түүнчлэн Эрхийн улсын бүртгэлд бүртгэгдсэн нийт үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээний мэдээллээс харахад 2020 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар 23983 үл хөдлөх хөрөнгө барьцаалагч иргэн 56996 үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээ байгуулсан байна. Харин банк, ББСБ, ХЗХ-ны аль нь ч биш бусад гэх 4137 хуулийн этгээдийн 91,988 барьцааны гэрээ байгуулан үл хөдлөх эд хөрөнгийг барьцаалсан тохиолдол бүртгэгдсэн байна.³

Манай улсын хувьд банк, ББСБ, ХЗХ гэх гурван этгээдийг ашгийн төлөө зээлийн үйл ажиллагаа эрхлэгч гэж хуульчилсан боловч барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа, иргэд хоорондын зээлийн үйл ажиллагааг ямар шалгуураар

² <http://www.judoinstitute.mn/main/244--2019-3-.html>

³ Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээллээс.

ашгийн төлөө зээлийн үйл ажиллагаа гэж үзэх талаар зохицуулалт байхгүй, улмаар B2C болон B2B зээлийг ялган зохицуулах шаардлага тулгарч байна.

Ази, Европи, Африк, Америк гэхчилэн дэлхийн олон тивийн улсуудад банк, банк бус санхүүгийн байгууллагаас гадна зөвхөн зээлийн үйл ажиллагаа явуулах этгээд, мөн барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа явуулах этгээдийг бүртгэлжүүлэн хянаж, зарим тохиолдолд тус тусдаа хуулиар, мөн хамтад нь нэг хуулиар тус харилцааг зохицуулж байна.

Энэ хэсэгт тус судалгаанд хамрагдах **Ази, Европи, Африкын** зарим улсуудын хуулиудыг танилцуулья.

	Улс	Хууль	Зохицуулах харилцаа
1.	БНСУ	Act on registration of credit business and protection of finance users 2002 ⁴	Зээлийн болон зээлийн зуучлалын үйл ажиллагааг бүртгэх, хянах; Хууль бус зээлийн хүүгийн хэмжээг зохицуулах; Зээлийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих; Санхүүгийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах; Тус хуулиар зохицуулах зээлийн үйл ажиллагаа гэдэгт “Хувь хүн, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид олгох зээлийн үйл ажиллагаа” болохыг тодорхойлсон.
2.	Япон	Money lending business act 1983 ⁵	Зээлийн үйл ажиллагаа явуулах этгээдийг бүртгэх; Зээлийн бизнесийн үйл ажиллагааг зохицуулах; Зээлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн холбоо болон хяналтын систем тогтоох; Зээлийн үйл ажиллагааны менежментийн зүй зохистой байдлыг дэмжих; Зээл хайж буй этгээдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах; Үндэсний эдийн засгийн зохистой менежментэд хувь нэмэр оруулах.
		Interest rate limitation act 1954 ⁶	Зээлийн хүүгийн дээд хэмжээг жилээр нь тогтоосон. Ингэхдээ 1 дүгээр бүлгээр хэрэглээний зээл, 2 дугаар бүлгээр арилжааны зээлийн хүүгийн талаар зохицуулсан. 100,000 иэнээс бага зээлийн хувьд жилийн

⁴ https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=47919&type=sogan&key=40

⁵ <http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?printID=&re=02&ky=additional+tax&ia=03&page=8&la=01&vm=02&lvm=02&id=1956>

⁶ <https://www.google.com/url?sa=t&rct=j&q=&esrc=s&source=web&cd=&cad=rja&uact=8&ved=2ahUKEwi4>

			20 хувийн хүүтэй байх. 100,000-1,000,000 иений зээлийн хувьд жилийн 18 хувийн хүүтэй байх. 1,000,000 иенээс дээш зээлийн хувьд жилийн 15 хувийн хүүтэй байх. Түүнчлэн урьдчилан хүүг суутгахдаа дээрх хэмжээнээс илүү хэмжээгээр хүүг бодсон бол илүүдэл мөнгийг үндсэн зээлийн төлбөрт тооцон хасах, нэршлээс үл хамааран зээлдэгчээс авсан бүх төлбөр, хураамж гэхчилэн бүх мөнгийг хүү гэж тооцох, хүү болон үндсэн зээлийн харьцаанд хязгаарлалт тогтоосон (нийт төлөх хүү үндсэн зээлийн 1.46 дахин илүү байж болохгүй) энэ тохиолдолд илүүдэл хэсгээр хүчингүй болно.
3.	Малайз	Pawnbrokers act 1972 ⁷	Барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагааг хянах, барьцаалан зээлдэгч болон барьцааны эрх зүйн хамгаалалт, тус үйл ажиллагаатай холбоотой харилцаа 10,000 рингитийн барьцаалан зээл олгох үйл ажиллагааг зохицуулахаар хуульд тодорхойлсон.
		Moneylenders act 1951 ⁸	Зээлийн үйл ажиллагааг хянах, зээлдэгч болон зээлтэй холбоотой асуудлуудыг хамгаалах, зохицуулах.
4.	Сингапур	Pawnbrokers act 2015 ⁹	Барьцаалан зээлдүүлэх бүртгэлтэй үйл ажиллагааг зохицуулах.
		Moneylenders act 2008 ¹⁰	Зээлийн үйл ажиллагааг хянах, зээлдэгчийн эрх ашгийг хамгаалах.
5.	Эстони	Creditors and Credit Intermediaries Act 2015 ¹¹	Зээлийн үйл ажиллагаа эрхлэгч болон зээлийн зуучлалын үйл ажиллагаа эрхлэгчийн үйл ажиллагаа, хариуцлага, үйл ажиллагаанд тавих хяналтыг зохицуулна.

v9mn_lfrAhWQ7WEKHQ0fD0oQFjACegQIBBAB&url=http%3A%2F%2Fwww.japaneselawtranslation.go.jp%2F%2F%2Fdetail_download%2F%3Fff%3D09%26id%3D2134&usg=AOvVaw0j9y58-1jPWgmJL7lpxinL

⁷ http://www.commonlii.org/my/legis/consol_act/pa1972152/

⁸ http://www.commonlii.org/my/legis/consol_act/ma19511989233/

⁹ <https://sso.agc.gov.sg/Act/PA2015>

¹⁰ <https://sso.agc.gov.sg/Act/MA2008>

¹¹ <https://www.riigiteataja.ee/en/eli/507052015001/consolide>

6.	Гүрж	Law on microfinance organisations ¹²	GEL 50,000 хүртэлх мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчийг бүртгэх, хянах.
7.	Ирланд	Consumer credit act 1995 ¹³	Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчдийг бүртгэх, үйл ажиллагааг нь зохицуулна.
		Pawnbrokers act 1964 ¹⁴	Барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагааг зохицуулна Нэр томьёоны тодорхойлох хэсэгт барьцаалан зээлдүүлэх газрын зээлийн хэмжээ 50 паундаас хэтрэхгүй байхаар зохицуулсан байна.
8.	Канад	Pawnbrokers act 1990 ¹⁵	Барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагааг зохицуулна.
9.	Намиби	Microlending act 2018 ¹⁶	Бага хэмжээний зээл гэснийг тодорхойлж, ийм зээл олгох хувь хүн, хуулийн этгээдийг бүртгэх, тус үйл ажиллагаатай холбоотой асуудлыг зохицуулсан. Зээлийн хэмжээг N\$100,000 байхаар тодорхойлсон. Зээлийн хугацааг 60 хоног, эсхүл Сангийн сайдаас тодорхойлсон хугацаа байхаар тодорхойлсон.
10.	Ямайка	Microcredit act 2019 ¹⁷	Жижиг зээлийн үйл ажиллагаа эрхлэгчийг бүртгэж, үйл ажиллагааг нь хянах үйл ажиллагааны зохистой байдлыг хуульчилсан. Тус хуулийн нэр томьёоны хэсэгт бичил зээл гэснийг хувь хүн, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид олгох зээлийг ойлгохоор тодорхойлсон.

Иргэд хоорондын мөнгөн зээлийн үйл ажиллагаа болон барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагааны нөгөө талд хэрэглэгч болох зээлдэгч гол төлөв иргэн байх буюу зарим улс хэрэглэгчийн зээлийн үйл ажиллагааны тухай хуульд уг зээлийн үйл ажиллагааг хамааруулж, зарим улс эдгээр субъектээс олгох зээлийн хэмжээг зааж бичил зээл гэж нэрлэн, зарим улс эдгээр субъектээс олгох зээлийн нөгөө тал нь хувь хүн, эсвэл жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч байна гэж тодорхойлох байдлаар B2C буюу бизнесээс хэрэглэгч рүү чиглэх харилцааг ялгажээ.

¹² <https://matsne.gov.ge/en/document/download/24328/9/en/pdf>

¹³ <http://www.irishstatutebook.ie/eli/1995/act/24/enacted/en/print>

¹⁴ <http://www.irishstatutebook.ie/eli/1964/act/31/enacted/en/print>

¹⁵ <https://www.ontario.ca/laws/statute/90p06>

¹⁶ <https://www.lac.org.na/laws/annoSTAT/Microlending%20Act%207%20of%202018.pdf>

¹⁷ <https://japarliament.gov.jm/attachments/article/339/The%20Microcredit%20Act,%202019----.pdf>

Япон, Малайз, Англи, Ирланд гэхчилэн улсуудад тус үйл ажиллагааг зохицуулах хууль нь 1990 оноос өмнө батлагдсан байхад Европын зарим улс, Эстони, Гүрж, зарим Азийн улс болох Солонгос, Сингапур гэхчилэн улсууд түүнчлэн сүүлийн үед Африк тивийн зарим улс болох Намибиа, Ямайка гэхчилэн улсуудад эдгээр үйл ажиллагааг зохицуулах шинэчлэл хийгдсэн байна.

Гүрж, Намибиа, Ямайка улсын хувьд “бага хэмжээний зээл” гэснийг тодорхойлон мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч олгож болох зээлийн хэмжээг тодорхойлсон байна. Харин Ирланд, Малайз улсын хуульд барьцаалан зээлдүүлэх зээлийн хэмжээг тодорхойлсон байна.

Солонгос, Ямайка улсын хувьд тус үйл ажиллагаа эрхлэгчээс олгох зээлийн зээлдэгч нь хувь хүн, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч байхыг хуульчилсан байгаа нь ангиллын хувьд хэрэглэгчийн зээл бөгөөд B2C харилцаа болохыг тодорхойлсон байна.

2. БҮРТГЭЛ

Манай улсын хувьд иргэд хооронд болон зээлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлгүй компаниуд ямар ч хяналтгүйгээр тус үйл ажиллагааг гүйцэтгэж байна.

Түүнчлэн ломбардууд зээлийн хүүг дураараа нэмэгдүүлэх, өндөр түвшинд барих, анз (алданги, торгууль) тооцох, цөөн хоногийн хугацаатай өндөр хүү, алдангитай зээл өгч мөнгө хүүлэх, иргэдийн барьцааны эд зүйлийн үнэлгээг багаар тогтоох, барьцааг зарж борлуулсан бол зөрүү мөнгийг буцаан олгохгүй байх, барьцаанд авах эд зүйлийг төрөлжүүлж зааснаар хулгайн гэмт хэргийн тоо нэмэгдэхэд нөлөөлөх зэргээр иргэдийн эрх ашгийг ноцтой зөрчсөөр байна.

Судалгаанд хамрагдсан улсуудын хувьд эдгээр үйл ажиллагааг бүртгэх, бүртгэд тусгай шаардлага тавьж, тодорхой шаардлага хангасан этгээд уг үйл ажиллагааг эрхлэх боломжтой байх, бүртгэснээр хяналт хэрэгжүүлэх механизмыг бий болгосон байна.

	Улс	Бүртгэх байгууллага	Бүртгэлийн хугацаа, ил тод байдал	Бүртгэлд өөрчлөлт оруулах
1.	БНСУ	Холбогдох орон нутгийн Засаг даргад бүртгүүлнэ. Өөр өөр орон нутаг буюу дор хаяж 2 хот, дүүрэгт, том хувьцаа эзэмшигч нь банк, ББСБ бол, 10 тэр бум воноос хэтэрсэн хөрөнгийн үнэлгээтэй хуулийн этгээд бол Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлнэ.	3 жил Нийтэд нээлттэй байна (хувийн мэдээллээс бусад) Мөн хүчингүй болгосон болон түдгэлзүүлсэн тохиолдолд ил тод байлгана.	Бүртгэлийн асуудлаар өөрчлөлт оруулахад 15 өдрийн дотор холбогдох бүртгэлийн байгууллагад мэдэгдэх, хаах тохиолдолд мөн мэдэгдэнэ. Мөн түүнчлэн бүр мөсөн хаахаар шийдвэрлэсэн бол мэдэгдэнэ. Ашиг сонирхлын зөрчил үүсгэхүйц үйл ажиллагаа явуулахыг хориглосон.

		Бүртгэлийн хураамж төлнө.		
2.	Япон	Нэг нутаг дэвсгэрт нэг болон хэд хэдэн салбар бүртгүүлэх бол харьяа орон нутгийн Засаг даргад , өөр өөр нутаг дэвсгэрт бүртгүүлэхээр бол Ерөнхий сайдад хандах бүртгүүлнэ. Бүртгэлийн хураамж төлнө.	3 жил (Нийтэд нээлттэй байлгана)	Байршил солих гэхчилэн бүртгэлд бүртгүүлсэн мэдээлэлд өөрчлөлт орвол 14 хоногийн дотор заавал мэдэгдэнэ.
3.	Малайз	Барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагааг явуулахыг хүссэн этгээдийг Орон нутгийн асуудал эрхэлсэн сайдын томилсон бүртгэгч бүртгэнэ. Бүртгэлийн хураамж төлнө.	2 жил Тусгай зөвшөөрөл эзэмшигч үйл ажиллагаа явуулах байршилдаа тусгай зөвшөөрлийг ил харагдах газар байршуулна. Хэрэв үүнийг зөрчвөл зөрчлийн хариуцлага хүлээнэ.	
		Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэхийг хүссэн этгээд нь Орон нутгийн асуудал эрхэлсэн сайдын томилсон бүртгэгч бүртгүүлнэ. Тус бүртгэгч нь өөрийн чиг үүргийг төрийн албан хаагчид шилжүүлж болно. Бүртгэлийн хураамж төлнө.	2 жил Тусгай зөвшөөрөл эзэмшигч үйл ажиллагаа явуулах байршилдаа тусгай зөвшөөрлийг ил харагдах газар байршуулна. Хэрэв үүнийг зөрчвөл зөрчлийн хариуцлага хүлээнэ.	Нэг тусгай зөвшөөрлөөр нэг хаяган дор үйл ажиллагаа явуулна. Жинхэнэ нэр, бизнес явуулах нэрийг тусгай зөвшөөрөл дээр заавал бичнэ. Зөрчвөл 5000 рингитээр торгох, мөн хоёр дахь удаагаа зөрчвөл хувь хүн бол 12 сар хүртэл хугацаагаар хорих, хуулийн этгээд бол бол 100,000 рингитээр торгоно.
		Барьцаалан зээлдэх үйл ажиллагаа эрхлэгчийг Сайдын томилсон бүртгэгч бүртгэнэ.	Олгосон жилийн 12 сарын 31 хүртэл эсхүл бүртгэгчийн тусгасан огноо Тусгай	Байршил сольж болохгүй, байршилд өөр үйл ажиллагаа явуулж болохгүй. Хэрэв өөр үйл ажиллагаа явуулахаар бол заавал мэдэгдэж

4.	Сингапур	Бүртгэлийн хураамж төлнө.	зөвшөөрлийг нийтэд ил харагдах байдлаар ажлын байрандаа байлгана.	зөвшөөрөл авна.
		Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчийг Сайдын томилсон бүртгэгч бүртгэнэ. Бүртгэлийн хураамж төлнө.	1 жилийн хугацаанд хүчинтэй байна. Тусгай зөвшөөрлийг нийтэд ил харагдах байдлаар ажлын байрандаа байлгана.	Тухайн байршилдаа үйл ажиллагаагаа явуулна.

5.	Эстони	Санхүүгийн зохицуулах хороо нь бүртгэнэ. Зээлийн үйл ажиллагаа эрхлэгч, зээлийн зуучлалын үйл ажиллагаа эрхлэгч, орон сууцны ипотекийн зээлдэгч, орон сууц барьцаалан зээл олгогч гэхчилэн төрлөөр бүртгэнэ. Бүртгэлийн төлбөр төлнө.	Хугацаа заагаагүй. Бүртгэх, хүчингүй болгох, бүртгэлийн гэрчилгээ олгохоос татгалзсан шийдвэр гарсны дараа холбогдох шийдвэрийг СЗХ-ны веб сайтад болон доод тал нь нэг үндэсний хэмжээний өдөр тутмын сонинд байршуулж олон нийтэд мэдээлнэ. Бүртгэлийн жагсаалтанд бүртгэгдсэн этгээдийг нэмнэ. Тус жагсаалт нь вебсайт дээр нийтэд ил тод байна. Үйл ажиллагааг нь зогсоосон зээлийн үйл ажиллагаа эрхлэгчийг нэн даруй жагсаалтаас гаргана.	Байршил, байрыг арилжааны бүртгэлд бүртгэнэ.
----	--------	--	--	---

6.	Гүрж	Төв банк бүртгэнэ. Гүрж улсын хуулийн дагуу байгуулагдсан компани бичил зээлийн үйл ажиллагаа явуулахаар бүртгүүлнэ. Хамгийн гол зүйл нь бичил санхүүгийн байгууллагын нэг хүнд олгох зээлийн дээд хэмжээ нь GEL 50,000-аас хэтрэхгүй байна. Түүнчлэн хуулийн 4 дүгээр зүйлд бичил санхүүгийн байгууллагын явуулж болох үйл ажиллагааг хуульчилсан байна. Тухайлбал, хэрэглэгчийн зээл, ипотека, барьцаалан зээлдүүлэх, барьцаат болон барьцаагүй зээл, түүнчлэн улсын үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийх, мөнгөн гуйвуулга хийх, бичил зээлтэй холбоотой зээлийн зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэх, тухайн бичил санхүүгийн байгууллагын хөрөнгийн 15 хувиас хэтрэхгүй хэмжээнд хуулийн этгээдийн хувьцаанд хувь эзэмших, жижиг лизинг, факторинг, валютын арилжаа, бонд худалдаа гэх	Хугацааны талаар заагаагүй.	
----	------	---	-----------------------------	--

		мэт. Хадгаламжийн үйлчилгээ явуулахыг хориглоно.		
7.	Ирланд	Хэрэглэгч гэснийг тодорхойлсон. Хувь хүн хэрэглэгч байна. Хувь хүнд олгох зээл олгох үйл ажиллагааг хэрэглэгчийн асуудал эрхэлсэн газрын захирал бүртгэнэ. Бүртгэлийн хураамж төлнө.	12 сарын хугацаанд хүчинтэй байна.	Зөвхөн мөнгөн зээлийн үйл ажиллагааг эрхлэнэ. Тусгай зөвшөөрөлд заасан байршилд үйл ажиллагаагаа явуулна. Хэрэв зөрчвөл тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.
		50 паундаас ихгүй мөнгөн зээлийг барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа эрхлэхийг хүссэн этгээд Revenue commissioner-т бүртгүүлнэ.	Дараагийн жилийн 7 сарын 31-ний өдөр хүртэл.	
8.	Канад	Барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагааг бүртгүүлэхээр орон нутгийн байгууллагад хандана. Бүртгэлийн хураамж төлнө.	1 жилийн хугацаагаар олгоно.	Нэг тусгай зөвшөөрлөөр зөвхөн нэг байршилд үйл ажиллагаа явуулна. 2 болон түүнээс дээш этгээд нөхөрлөл хэлбэрээр үйл ажиллагаа явуулахаар бол нэг тусгай зөвшөөрлөөр нэг байршилд үйл ажиллагаа явуулна.
9.	Намиби	Санхүүгийн зохицуулах хороонд бичил зээлийн үйл ажиллагаа эрхлэгч бүртгүүлнэ. Бүртгэлийн хураамж төлнө.	1 жилийн хугацаанд хүчинтэй байна.	Тусгай зөвшөөрөл авсан байршилд өөр үйл ажиллагаа эрхлэхээр бол СЗХ-нд мэдэгдэн зөвшөөрөл авна. Хэрэв ийм үйл ажиллагааг тухайн байршлаас явуулахар болвол мөнгөн зээлийн үйл ажиллагааны банкны дансыг тухайн өөр төрлийн бизнесээс

				тусдаа байлгана. Хэрэв тухайн бизнес нь нийтийн ашиг сонирхолд харшлахааргүй тус хуульд заасантай нийцэхээр бол бүртгэлд нь тусгай нөхцөлийг бичиж батална. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч нь энэ процедурыг зөрчвөл N500,000 -аар торгуулих эсвэл 5 жилээс доош хугацаагаар хорих ялаар шийтгэх. Өөр салбар нээхээр бол дээрх журмаар СЗХ-нд мэдэгдэж батлууна. Мөн 30 өдрийн дотор шинэ салбарын менежер томилж 14 өдрийн дотор мэдэгдэнэ. Шаардлага хангасан байх ёстой.
10.	Ямайка	Хувь хүн, жижиг дунд бизнес эрхлэгчдэд олгох зээлийн үйл ажиллагааг эрхлэгч нь Банкны тухай хуульд заасан Хянагчид бүртгүүлнэ. Төв банк, СЗХ хяналт тавина. Бүртгүүлэх, хаах, байршилаа солих, шинэ байршил нээх, нэр өөрчлөх	1 жилийн хугацаанд, эсвэл хянагчийн тогтоосон түүнээс илүү хугацаагаар олгоно. Өдрийн сонинд нийтэлнэ. Хаах талаарх мэдээллийг мөн нийтэлнэ.	Байршилаа солих болон шинэ салбар нээх бол мэдэгдэх ёстой. Мөн яагаад байршил солих болсон үндэслэл, шинэ байршил нь стандартад нийцсэн байх ёстой. Шинэ салбар нээх бол мөн байршлын талаар мэдээлэл, ажиллах хүчин, тухайн салбараар үйлчлүүлэх хэрэглэгчдийн тооцоолол, санхүүгийн төсөл, санхүүжилтийн талаар мэдэгдэнэ. Хэрэв мэдэгдэх, баталгаажуулах үүргээ биелүүлээгүй бол зөрчлийн хариуцлага хүлээнэ. Хэрэв үйл ажиллагаагаа

		өргөдөл гаргах бүрт хураамж төлнө.		зогсоох болон хаах гэж байгаа, эсвэл салбараа хаах гэж байгаа бол мөн 6 сарын өмнөөс мэдэгдэнэ. Эс бөгөөс зөрчлийн хариуцлага хүлээнэ. Бүртгэлд өөрчлөлт орох бүрд мэдэгдэнэ. Мөн эс биелүүлбэл зөрчлийн хариуцлага хүлээнэ. Тусгай зөвшөөрөл эзэмшигч зөвхөн мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэнэ.
--	--	------------------------------------	--	---

Бүртгэлийн хугацааны хувьд ихэнхи улсад 1 жил зарим улсад, тухайлбал Солонгос, Япон, Малайз улсад 2-3 жил байна. Харин Гүрж, Эстони улсад бүртгэлийн хугацаа заагаагүй байна.

Судалгаанд хамрагдсан ихэнхи улсуудын хувьд орон нутгийн байгууллага, Санхүүгийн зохицуулах хороо бүртгэж хянахаар заасан байна.

Эстони улсын хувьд нэг онцлог зохицуулалт нь мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчийг орон сууцны ипотекийн зээлдүүлэгч, орон сууц барьцаалан зээл олгогч гэхчилэн төрлөөр нь бүртгэж байна.

Сингапур, Малайз улсын хувьд тусгай зөвшөөрлийг үйл ажиллагаа явуулах байршилдаа ил харагдах байдлаар байршуулах үүргийг хуульд заасан байна.

Түүнчлэн тусгай зөвшөөрөлд заасан байршилд зөвхөн зээлийн үйл ажиллагаа явуулах, байршлаа солих бол мэдэгдэх, хаах болон бүр мөсөн хааж байгаа бол мэдэгдэх зөвшөөрөл авах зохицуулалт нийтлэг байна.

Манай улсын хувьд барьцаалан зээлдүүлэх үйлчилгээний стандартын 7.11-д зааснаар “Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээний газар нь хүнсний дэлгүүр, согтууруулах ундааны борлуулалт, үйлчилгээ явуулж буй эзэмшил талбайд байрлах болон үйл ажиллагаа эрхлэн явуулах”-ыг хориглосон боловч барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагааг тусгай зөвшөөрөл бүхий байршилд явуулах шаардлага тавиагүй буюу байршлаа солих болон хаах тохиолдолд мэдэгдэх зохицуулалт байхгүй байна.

Байршлаа солих, шинэ салбар нээхдээ мэдэгдэх зэргээр бүртгэлийн зохицуулалтыг хуульчилснаар зээлдэгч тал сольсон байршлыг мэдэх, түүнчлэн шинэ салбар нээх шаардлага бий эсэхийг нягтлах ач холбогдолтой. Жишээлбэл, Манай улсын хувьд 1 аж ахуй нэгж 30-40 салбартай үйл ажиллагаа явуулж байгаа болно.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын нээлттэй мэдээллээс харахад, нэг аж ахуй нэгж барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаанаас гадна 3-5 үйл ажиллагаа эрхэлдэг, бүр 12 өөр төрлийн үйл ажиллагаа эрхэлж байна.

Түүнчлэн Ирланд, Ямайка улсын хувьд мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч нь зөвхөн мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх, өөр үйл ажиллагаа эрхлэхийг нь хориглон зохицуулсан байна.

3.МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХУВЬ ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭД ЭРХЭЛЖ БОЛОХ ЭСЭХ

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг эрхэлж болох буюу тус үйл ажиллагаа эрхлэгчээр бүртгүүлж болох этгээд нь ямар субъект байж болох талаар судалгаанд хамрагдсан улсуудын зохицуулалтаас түүвэрлэснийг доор үзүүлэв.

	Улсын нэр	Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд
1.	БНСУ	Хувь хүн, хуулийн этгээд
2.	Япон	Хувь хүн, хуулийн этгээд
3.	Малайз	Хувь хүн, хуулийн этгээд Хувь хүн, хуулийн этгээд
4.	Сингапур	Хувь хүн, хуулийн этгээд Хувь хүн, хуулийн этгээд
5.	Эстони	ХХК, худалдааны холбоо
6.	Гүрж	Компани
7.	Ирланд	Хувь хүн, хуулийн этгээд
8.	Канад	Хувь хүн, хуулийн этгээд
9.	Намиби	Хувь хүн, хуулийн этгээд
10.	Ямайка	Компани

Судалгаанд хамрагдсан улсуудын хувьд нийтлэг байдлаар хувь хүн, хуулийн этгээд мөнгөн зээлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөл, бүртгэлийн үндсэн дээр эрхлэх боломжтой.

Харин Гүрж, Эстони, Ямайка гэхчилэн улсад **зөвхөн компани, эсхүл ХХК** хэлбэрээр үйл ажиллагаа явуулах боломжтой байдлаар хуульчилсан байна.

Манай улсын хувьд хувь хүмүүс хооронд, эсхүл банк санхүүгийн байгууллагын тусгай зөвшөөрөлгүй мөртлөө компаниуд мөнгөн зээлийн үйл ажиллагааг үл хөдлөх хөрөнгө байрцаалж болон барьцаагүйгээр зээлж байна.

Иргэний хуулийн холбогдох зохицуулалтын хүрээнд энэ нь хориглогдоогүй буюу сул чөлөөтэй байгаа болно.

Мөн барьцаалан зээлдүүлэх үйлчилгээний хувьд аж ахуй нэгж байгууллага эрхлэх боломжтой байна.

**4. МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА
(ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ, ХУВЬ ХҮНД ТАВИГДАХ ХЯГААРЛАЛТ)**

	Улсын нэр	Гүйцэтгэх удирдлага, менежер тавигдах шаардлага	Хувьцаа эзэмшигчид тавигдах шаардлага
1.	БНСУ	Дараах этгээд мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчээр бүртгүүлж болохгүй. Үүнд: ▪ Насанд хүрээгүй этгээд; ▪ Эрх зүйн чадамжгүй эсхүл эрх зүйн зарим чадамжтай этгээд; ▪ Хувь хүний дампуурал зарласан этгээд; ▪ Шүүхийн шийдвэрээр хорих ялаар шийтгүүлсэн, эсхүл хэргийг хэрэгсэхгүй болгосноос хойш 5 жилийн хугацаа өнгөрөөгүй; ▪ Хорих ялын гүйцэтгэлийг нь түдгэлзүүлсэн; ▪ Тус хууль, эрүүгийн хуулийн холбогдох зүйл, хүчирхийлэлд хариуцлага хүлээлгэх тухай хууль, Зээлийн мэдээллийн ашиглалт болон хамгаалалтын тухай хууль, Өр цуглуулах үйл ажиллагааны тухай хууль, Хувь хүний нууцын тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн. Түүнчлэн СЗХ-нд бүртгүүлэх этгээдийн гүйцэтгэх захирал, менежер нь нэмэлтээр ерөнхийлөгчийн зарлигт заасан санхүүгийн хууль тогтоомжийг зөрчсөн үйлдэлд шүүхийн шийдвэрээр торгох ял, эсхүл үүнээс хүнд ялаар шийтгүүлсэн, эсхүл хэргийг хэрэгсэхгүй болгосноос хойш 5 жилийн хугацаа өнгөрөөгүй, тухайн этгээд корпарацн буюу компанийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байх үед тус компанийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, эсхүл бүртгэлийг санхүүгийн хууль тогтоомжийн дагуу цуцалснаас хойш 5 жилийн хугацаа өнгөрөөгүй,	Зээлдүүлэгчийн их хувьцаа эзэмшигчтэй хийх гүйлгээний нийт хэмжээ өөрийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний 100/100-с хэтрэхгүй байна.

		тухайн этгээд санхүүгийн хууль тогтоомжийн дагуу ажлаас халагдсан буюу чөлөөлөгдснөөс хойш 5 жилийн хугацаа өнгөрөөгүй байх хуулийн шаардлага тавигдана. Хэрэв тухайн этгээд гүйцэтгэх захирал эсхүл ерөнхий менежерээр томилогдсоны дараа дээрхэд хамаарах тохиолдол гарсан бол тухайн албан тушаалаас татгалзана.	
2.	Япон	Асран хамгаалалтад байгаа, дампуурсан, үйл ажиллагааг нь зогсоосноос хойш 5 жилийн хугацаа нь дуусаагүй байгаа этгээд, хорих ялаар шийтгэгдсэнээс хойш 5 жил өнгөрөөгүй байгаа, санхүүгийн хууль тогтоомжийн дагуу торгуулийн шийтгэл оногдуулснаас хойш 5 жилийн хугацаа өнгөрөөгүй, зохион байгуулалттай бүлэглэлийн гишүүн, эсвэл бүлэглэлийн гишүүнээс гарснаас хойш 5 жил өнгөрөөгүй байх, Зээлийн үйл ажиллагааны бизнест итгэл эвдсэн, буруу үйлдэл хийж болзошгүй гэж тогтоогдсон, түүнчлэн зохион байгуулалттай бүлэглэлд тусалж болзошгүй, зохион байгуулалттай бүлэглэлээр удирдагдсан хүн, нийтийн ашиг сонирхолд харш өөр бизнес эрхлэдэг бол бүртгэхгүй. 50 сая иенээс багагүй хөрөнгөтэй байх шаардлага тавигдана.	
3.	Малайз	Хувь хүн өргөдөл гаргагч болон өргөдөл гаргагч нь компани бөгөөд захирал, менежер, удирдлагын албан тушаалд буй этгээдийн талаар дараах зүйл тогтоогдвол бүртгэхгүй ▪ Залилан, итгэл эвдсэн эрүүгийн хэрэг үйлдсэн, дампуурсан этгээд; ▪ Өргөдөл гаргах үед Энэ хуулийн дагуу шийтгэгдсэн (10 мянган рингитээс дээш торгууль, эсхүл хоригдсон) ; ▪ Бүртгэл нь хүчингүй болсон бол; ▪ Уг үйл ажиллагааг эрхлэхэд	Голлох хувьцаа эзэмшигч нь өөрчлөгдөх, голлох хувьцаа эзэмшигчийн хувьцааны хэмжээ багасах болон ихсэх, голлох хувьцаа эзэмшигч байхаа болих тохиолдолд мэдэгдэнэ. Хэрэв зөрчвөл торгох, эсвэл хорих

		муу зан авиртай эсхүл тэнцэхгүй, зохихгүй бол. Удирдах албанд байх этгээдүүд өөрчлөгдөх, болих, болох тохиолдолд мэдэгдэнэ. Хэрэв зөрчвөл торгох, эсвэл хорих ялтай. 9 дүгээр зүйл.	ялтай. 9 дүгээр зүйл.
4.	Сингапур	Бүртгэгчийн зөвшөөрөлгүйгээр захирал, менежерээр томилохыг хориглоно. Дараах шаардлагыг хангаагүй бол татгалзана. Үүнд ▪ 21 наснаас доош настай; ▪ Эрх зүйн чадамжгүй; ▪ Сайн зан чанартай биш гэж үзсэн; ▪ Тусгай зөвшөөрөл олгоход тохиромжгүй үйл ажиллагаа явуулсан гэж үзсэн; ▪ Тусгай зөвшөөрөл олгоход тохиромжгүй гэж үзсэн.	Гол хувьцаа эзэмшигч нь эрх зүйн чадамжгүй байх; Гол хувьцаа эзэмшигч нь тусгай зөвшөөрөл олгоход тохиромжгүй үйл ажиллагаа явуулсан гэж үзсэн бол бүртгэхгүй. Голлох хувьцаа эзэмшигчийн мэдээллийг бүртгэгчийн баталгаагүйгээр бүртгэх (хувьцааны хэмжээг нэмэгдүүлэх, шинээр голлох хувьцаа эзэмшигчээр бүртгэх) мэдэгдэлгүйгээр өөрчилсөн бол зөрчил болно. Гэхдээ хувьцаа эзэмшлийг нь бүхлээр нь болиулах утгатай бус, зөвхөн голлох хувьцаа эзэмшигч болгохгүйн тулд хувьцааны хувь хэмжээг багасгах агуулгатай. Хэрэв тухайн этгээд нь шаардлага хангахгүй, тухайн тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг явуулахад тохиромжгүй үйл ажиллагаа явуулсан бол бүртгэхгүй.
		Өргөдөл гаргагчийн захирал, эсвэл	

		менежментийн хувьд хариуцлага хүлээх этгээд нь Сингапурт оршин суудаггүй, 21 наснаас доош, байр нь тохиромжгүй гэж үзсэн, Өргөдөл гаргагчийн захирал, менежмент хариуцсан этгээд, голлох хувьцаа эзэмшигч нь ёс зүй болон итгэл эвдсэн хэрэгт шийтгэгдсэн, авилгын хэрэгт ял шийтгүүлсэн, мансууруулах бодис худалдсан, хилээр оруулсан, терроризм, санхүүгийн хүнд хэрэгт шийтгэгдсэн, энэ хуульд заасан хариуцлага хүлээсэн, тус үйл ажиллагааг эрхлэхэд зохимжгүй гэж үзсэн бол бүртгэхгүй. Тухайн үйл ажиллагааг явуулахад сайн зан чанартай, тохиромжтой эсэхийг шалгуур болгодог. Түүнчлэн мэдлэг, туршлага хангалттай байгаа эсэхийг анхаарна. Эдгээр шаардлага нь ажилтнуудад ч мөн хамааралтай байна. Эдгээр үндэслэлээр тусгай зөвшөөрөл олгох болон шинэчлэхээс татгалзаж болно.	
5.	Эстони	Хэрэв өргөдөл гаргагчийн менежер, аудитор, хувьцаа эзэмшигчид тус хуульд заасан шаардлагыг хангаагүй эсвэл хангахгүй болсон, хяналт тавих этгээдтэй ойрын харилцаа холбоотой нь тогтоогдсон, менежер нь эдийн засгийн гэмт хэрэг, өмчийн эсрэг хэрэг, олон нийтийн итгэлийг эвдэх хэрэг, терроризмыг санхүүжүүлэх, дэмжих гэмт хэрэгт ял шийтгүүлсэн бол бүртгэлийг хийхгүй мөн шинэчлэхгүй. Харин өргөдөл гаргагч, менежер, захирал болон хувьцаа эзэмшигчид тавигдах энэ хуульд тусгасан шаардлага гэдэгт өргөдөл гаргагч нь хуулийн этгээд бол үйл ажиллагааны зохион байгуулалт, техникийн удирдлага, менежмент хариуцсан этгээдийн боловсрол, туршлагын түвшин, бизнесийн харилцаа холбоо, нэр хүнд, итгэл даах байдал, өргөдөл гаргагчийн	Хэрэв өргөдөл гаргагчийн менежер, аудитор, хувьцаа эзэмшигчид тус хуульд заасан шаардлагыг хангаагүй эсвэл хангахгүй болсон, хяналт тавих этгээдтэй ойрын харилцаа холбоотой нь тогтоогдсон, менежер нь эдийн засгийн гэмт хэрэг, өмчийн эсрэг хэрэг, олон нийтийн итгэлийг эвдэх хэрэг, терроризмыг санхүүжүүлэх, дэмжих гэмт хэрэгт ял шийтгүүлсэн бол бүртгэлийг хийхгүй мөн шинэчлэхгүй.

		бизнес төлөвлөгөөний хангалттай үндэслэлтэй байдал, бизнесийн нэр хүнд, санхүүжилт, санхүүгийн байдал, туршлага зэргийг харгалзана. 39 дүгээр зүйлд зааснаар менежерт дараах шаардлага тавигдана. Үүнд Зөвхөн зээлийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай мэдлэг, чадвар, туршлага, боловсрол, мэргэжлийн чадвартай, бизнесийн нэр хүндтэй этгээдийг менежерээр томилно. Нэгдүгээр ангиллын гэмт хэрэг үйлдсэн, түүний үйлдлийн улмаас дампуурсан, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг нь хассан, хэрэглэгчдийн эрхийг хангалттай хамгаалах байдлаар үйл ажиллагааг зохицуулах чадваргүй этгээд, буруу ташаа мэдээлэл СЗХ-нд мэдүүлсэн, эдийн засгийн гэмт хэрэг, өмчийн эсрэг хэрэг, олон нийтийн итгэлийг эвдэх хэрэг, терроризмыг санхүүжүүлэх, дэмжих гэмт хэрэгт ял шийтгүүлсэн гэх зэрэг байдлыг харгалзана.	
6.	Гүрж	Захирал (Захирлуудын зөвлөлийн гишүүн) нь нэгэн зэрэг арилжааны банк, ББСБ, зээлийн холбооны хяналтын зөвлөл, эсвэл төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, хувьцаа эзэмшигч байж болохгүй. Дараах этгээд бичил санхүүгийн байгууллагын захирал байхыг хориглоно. ▪ Банк, ББСБ, бичил санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд томоохон хохирол учруулсан, эсвэл дампуурахад хүргэсэн; ▪ Банк, ББСБ, бичил санхүүгийн байгууллагад төлөх ёстой санхүүгийн үүргээ биелүүлээгүй; ▪ Хүнд хэрэг үйлдсэн ялангуяа	Хүнд хэрэг үйлдсэн ялангуяа терроризмыг санхүүжүүлэх, хууль бус орлогын болон эдийн засгийн хэрэгт ял шийтгэл хүлээсэн этгээд бичил санхүүгийн байгууллагад томоохон хувьцаа эзэмшихийг хориглоно. Томоохон хувьцаа эзэмшихийг хүссэн этгээд Төв банк-нд энэ тухай мэдэгдэнэ. Төв банкны санхүүгийн хяналтын алба энэ тохиолдолд 15 өдрийн дотор зөвшөөрөх, эсвэл

		терроризмыг санхүүжүүлэх, хууль бус орлогын болон эдийн засгийн хэрэгт ял шийтгэл хүлээсэн; Зохих ёсны боловсрол, туршлагагүй.	татгалзана. Хэрэв зөвшөөрөл авалгүй, эсвэл татгалзсан байхад томоохон хувьцаа худалдан авах гэрээг байгуулсан бол хүчингүй байна.
7.	Ирланд	-	
8.	Канад	-	
9.	Намибия	7 дугаар зүйл Дараах этгээд бичил зээлийн үйл ажиллагаа эрхлэгч, үндсэн ажилтан, салбарын менежрээр томилогдохыг хориглоно. - Сүүлийн 10 жилийн дотор хулгай, залилан, шударга бус итгэл эвдсэн, аливаа санхүүгийн хэрэгт ял шийтгүүлсэн; Намибия улсын иргэн биш; - Намибиад хууль ёсоор байнга оршин суудаггүй; - Хуулийн этгээдийн хувьд Намибиагийн хуулийн дагуу байгуулагдаагүй, эсвэл хувьцааны ихэнхийг Намибиан бус иргэн эсвэл Намибиад оршин суудаггүй этгээд эзэмшдэг бол; - Дампуурсан; - Зээлийн үйл ажиллагааны нэр хүндэд сөргөөр нөлөөлөх үйл ажиллагаа явуулсан бол.	Намибия улсын иргэн биш бол зээлийн үйл ажиллагаа эрхлэгчийн хувьцааны ихэнхийг эзэмших боломжгүй.
10.	Ямайка		19 дүгээр зүйл. Бичил санхүүгийн байгууллагад голлох хувьцааг эзэмшихийг хүссэн этгээд эхлээд хянагчид мэдэгдэж баталгаажуулна. Дараах зүйлсийг харгалзан үзнэ. Өргөдөл гаргагчийн санхүүгийн эх үүсвэрийн шинж, эх сурвалж, хангалттай байдал;

			Өргөдөл гаргагчийн бизнесийн туршлага; Тохиромжтой, зохистой эсэх; Ямайкагийн санхүүгийн системийн тогтвортой байдлын ашиг сонирхлыг харгалзана. Томоохон голлох хувьцаа эзэмшигч нь залилан, итгэл эвдэх гэмт хэрэгт шийтгүүлсэн бол тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлнэ.
--	--	--	---

Манай улсын хувьд хувь хүмүүс хоорондын ашгийн төлөө, тогтмол зээлийн үйл ажиллагааг ашгийн төлөө бус, тогтмол бус зээлийн үйл ажилагаанаас ялган зохицуулсан зохицуулалт байхгүй тул тэдгээрт тавигдах шаардлага байхгүй.

Харин барьцаалан зээлдүүлэх үйлчилгээний хувьд тус үйл ажиллагааны стандартад зааснаар “Үйлчилгээний газрын ажилтан, алба хаагч нь сургалт, зөвлөгөөнд хамрагдаж, сертификаттай байна” гэснээс өөр шаардлага тавигдаагүй байна.

Хувьцаа эзэмшигч нь хэн байх, томоохон хувьцаа эзэмшигчид тавигдах шаардлага болон энэ талаар бүртгэсэн хяналт тавьж буй байгууллагад мэдэгдэх асуудлыг хуульчлаагүй.

Харин судалгаанд хамрагдсан улсуудын хувьд удирдах ажилтан, менежер, гүйцэтгэх захиралд холбогдох гэмт хэрэгт ял шийтгэл эдлээгүй, зан авирын болон хийж буй болон хийсэн ажил нь мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэхэд тохиромжтой байх, мэдлэг туршлагын хувьд хангалттай байх гэхчилэн шаардлага тавьж байна.

Энэхүү шаардлагыг зарим улсын хувьд голлох хувьцаа эзэмшигчид хүртэл тавьсан байна. Харин Намибиа улсын хувьд тухайн улсын иргэн биш бол голлох хувьцаа эзэмшигч байх боломжгүй, мөн мөнгөн зээлийн үйл ажиллагааг тухайн улсын иргэн эрхлэхээр заасан онцлог зохицуулалттай байна.

Түүнчлэн эдгээр удирдах албан тушаалтан болон голлох хувьцаа эзэмшигч нар солигдох бүрт мэдэгдэх, зөвшөөрөл авах шаардлага хуулиар тавигдсан байна.

5. САНУУЛАХ, ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ

Улс	Түдгэлзүүлэх	Хүчингүй болгох
	Дараах тохиолдолд хотын Захирагч, эсхүл Санхүүгийн	Харин дараах тохиолдолд үйл ажиллагаа явуулах бүртгэлийг хүчингүй болгоно.

1.	БНСУ	үйлчилгээний хороо нь зээлдүүлэгч, эсхүл зээлийн брокерийн үйл ажиллагааг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн 1 хүртэлх жилийн хугацаагаар түр зогсоох тушаал гаргана. Зээлдүүлэгч, эсхүл брокер нь Хавсралт 1 болон Өр цуглуулах ажиллагааны тухай хуулийн 5(1), 7-9, 10(1) болон 11-13 дугаар зүйлийг зөрчсөн. Нэг хотын Захирагчид бүртгэлтэй зээлдүүлэгч, эсхүл зээлийн брокерийн бизнесийн салбаруудын нэгнийх нь үйл ажиллагааг түр зогсоосон бол бусад салбарын үйл ажиллагаа.	Хууран мэхлэх аргаар бүртгүүлсэн, эсхүл бүртгэлийн хугацааг сунгасан; Сүүлийн 5 жилийн хугацаанд хуульд заасан хэрэгт шийтгэл хүлээгээсэн; Ерөнхийлөгчийн зарлигт тодорхойлсон ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй бизнесийн үйл ажиллагаа эрхэлсэн; Их хувьцаа эзэмшигч корпорацийн менежменттэй холбоотой үндсэн асуудлыг шийдвэрлэхэд де факто нөлөөлсөн хувьцаа эзэмшигч байвал; 6 сараас багагүй хугацаагаар үйл ажиллагаагаа эрхлээгүй; Түр зогсоох шийдвэрийг зөрчсөн бол; Түр зогсоох шийдвэрийг хүлээн авсны дараа зөрчлийг арилгаагүйн улмаас дахин үйл ажиллагааг зогсоох тушаал гаргасан бол; Хаягийг тодруулахаар нийтэд зарласнаас хойш 30 хоногийн хугацаа өнгөрсөн бол; Нэг хотод бүртгэлтэй зээлдүүлэгчийн салбаруудынх нь нэгийнх нь бүртгэлийг хүчингүй болгосон бол бусад салбарын бүртгэлийг хүчингүй болгоно.
		6 сарын хугацаанд үйл ажиллагаагаа явуулаагүй; 30 хоногийн дотор олон нийтэд танилцуулснаас хойш	Байршлаа өөрчлөн үйл ажиллагаа явуулсан, нас

2.	Япон	байршил нь тогтоогдохгүй бол; Дампуурсан, асран хамгаалалтанд орсон, нэр дээрээ өөр этгээдээр үйл ажиллагаа явуулуулсан, зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн үйл ажиллагаанд туслах гэхчилэн тохиолдолд түдгэлзүүлнэ.	барсан гэхчилэн хуульд заасан тохиолдлуудад хүчингүй болгоно.
3.	Малайз	Нийтийн эрх ашиг сонирхолд харш үйл ажиллагаа явуулсан; Дампуурсан; Шүүхээс татан буугдсан компани, нөхөрлөл; Энэ хуулийг зөрчсөн үйлдэл; Хууран мэхлэх замаар тусгай зөвшөөрөл авсан, бүртгэгчийн тавьсан шаардлагыг биелүүлээгүй бол хүчингүй болгоно.	Нийтийн эрх ашиг сонирхолд харш үйл ажиллагаа явуулсан; Дампуурсан; Шүүхээс татан буугдсан компани, нөхөрлөл; Энэ хуулийг зөрчсөн үйлдэл; Хууран мэхлэх замаар тусгай зөвшөөрөл авсан, бүртгэгчийн тавьсан шаардлагыг биелүүлээгүй бол хүчингүй болгоно.
4.	Сингапур	Энэ хуулийг зөрчсөн, барьцаалан зээлдэх үйл ажиллагааг зохисгүй, хангалтгүй байдлаар явуулсан бол тусгай зөвшөөрлийн нөхцөлийг өөрчлөх, түдгэлзүүлэх эсхүл хүчингүй болгоно. Давж заалдаж болно.	Энэ хуулийг зөрчсөн, барьцаалан зээлдэх үйл ажиллагааг зохисгүй, хангалтгүй байдлаар явуулсан бол тусгай зөвшөөрлийн нөхцөлийг өөрчлөх, түдгэлзүүлэх эсвэл хүчингүй болгоно.
		Дампуурсан, татан буугдсан, 6 сарын хугацаанд үйл ажиллагаагаа явуулаагүй, хуурамч материал бүрдүүлж өгсөн, тусгай зөвшөөрлийн нөхцөлийг зөрчсөн, хангалтгүй, зохисгүй байдлаар үйл ажиллагаагаа явуулсан, тохиромжгүй байршилд үйл ажиллагаагаа явуулсан бол хүчингүй болгох эсвэл түдгэлзүүлнэ. Мөн Сайдад давж заалдах гомдол гаргаж болно.	Дампуурсан, татан буугдсан, 6 сарын хугацаанд үйл ажиллагаагаа явуулаагүй, хуурамч материал бүрдүүлж өгсөн, тусгай зөвшөөрлийн нөхцөлийг зөрчсөн, хангалтгүй, зохисгүй байдлаар үйл ажиллагаагаа явуулсан, тохиромжгүй байршилд үйл ажиллагаагаа явуулсан бол хүчингүй болгох, эсхүл түдгэлзүүлнэ.
		Тусгай зөвшөөрөл нь хугацаагүй болно.	Хүчингүй болгох тохиолдол Тусгай зөвшөөрөл авснаас хойш 12 сарын дотор үйл ажиллагаагаа эхэлж явуулаагүй; Тусгай зөвшөөрөл авахад нөлөөлсөн баримт бичиг нь худал байсан;

5.	Эстони		Үйл ажиллагаа нь тусгай зөвшөөрөл авах шаардлагыг хангахаа больсон; Менежер болон аудитор нь энэ хуульд заасан шаардлагыг хангахгүй; Зээлдүүлэгч нь эдийн засгийн гэмт хэрэг, терроризмыг санхүүжүүлэх, өмчийн эсрэг гэмт хэрэгт ял шийтгүүлсэн; Зээлдүүлэгч нь төөрөгдүүлсэн, буруу ташаа мэдээлэл хэвлэсэн тараасан, үйл ажиллагааны талаарх зар сурталчилгааг буруу ташаа мэдээлэл агуулан хийсэн бол.
6.	Гүрж		Хүчингүй болгох 3 дугаар зүйл
7.	Ирланд	11 дүгээр зүйл Хулгай, залилан, итгэл эвдэх гэмт хэрэгт холбогдсон, хулгайн эд зүйлс гэдгийг мэдсээр байж авсан бол түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгоно. Тус асуудлаар шүүхэд хандаж болно. Энэ нь эцсийн шийдвэр байна.	
8.	Канад	-	
9.	Намибиа	Бүртгэлд бүртгүүлэхдээ худал мэдээлэл илгээсэн; Энэ хуулийг зөрчсөн; Бүртгэлд бүртгэснээс хойш бүртгэлд бүртгүүлсэн үеийн шаардлагыг хангахаа больсон ; СЗХ-ны тавьсан шаардлагыг биелүүлээгүй; Мэргэжлийн нэгдмэл, чадварлаг, нямбай байдлаар үйл ажиллагааг явуулаагүй; Бүртгүүлснээс хойш үйл ажиллагаагаа боломжит хугацаанд эхлэн явуулаагүй; Өдрийн зээлийн хуульд заасан зээлийн хүүгийн дээд хэмжээнээс илүү хүү авсан; Сайдын тогтоосноос илүү хэмжээгээр торгууль төлбөр авсан; Намибиа улсад зөвшөөрөгдсөн бус банкаар дамжуулан гүйлгээ хийсэн; Стандарт шаардлагад нийцээгүй ажилтан авсан, шаардлага хангахаа больсон; Санхүүгийн хэрэгт шийтгүүлсэн; Энэ хуулийг зөрчсөн бол, тусгай зөвшөөрлийн нөхцөлийг өөрчлөх, шаардлагатай гэж үзсэн арга хэмжээ авах, хүчингүй болгоно.	
		25 дугаар зүйл Сануулга өгөх; Тухайн үйл ажиллагааг явуулахыг зогсоохыг шаардах; Түдгэлзүүлэх;	

10.	Ямайка	Хүчингүй болгох.	
		Түдгэлзүүлэх үндэслэл 26 дугаар зүйл Өөрөө түдгэлзүүлэхийг хүссэн; Голлох хувьцаа эзэмшигч эсвэл ажилтан нь залилан мэхлэх, итгэл эвдсэн хэрэгт холбогдсон Бичил зээлийн үйл ажиллагаанд хамаарахгүй үйл ажиллагаа явуулсан; Зээлийн үйл ажиллагаатай холбоотой бримт материалыг зүй зохистой хадгалаагүй; Мэдээлэх үүрэгтэй асуудлыг мэдээлээгүй; 7 жилийн хугацаанд тайланг хадгалаагүй; Тусгай зөвшөөрлийг зохих ёсоор байнга харагдах газар байршуулаагүй; Бусдад тусгай зөвшөөрлөө ашиглуулахыг зөвшөөрөх; Байршлаа солих талаар мэдээлээгүй.	Хүчингүй болгох үндэслэл Үүсгэн байгуулах баримт бичигт заасан үйл ажиллагааг зөрчиж, эсхүл зөрчихөд хүргэсэн үйл ажиллагаа явуулах; Тусгай зөвшөөрлийн нөхцөлийг зөрчсөн; Тусгай зөвшөөрөлд заасан хугацаанд үйл ажиллагаагаа эхлээгүй; Голлох хувьцаа эзэмшигч нь тохирох этгээд биш болсон боловч энэ талаар тодорхой арга хэмжээ аваагүй; Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эсрэг Шүүхийн шийдвэр гарсан бол хүчингүй болгоно.

6.ЗЭЭЛИЙН ХҮҮГИЙН ДЭЭД ХЭМЖЭЭНИЙ ХЯЗГААРЛАЛТ

Энэ хүрээнд мөнгөн зээлийн үйл ажиллагаанд зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоосон эсэх, ямар хязгаарлалтыг хуульчилсныг судлан авч үзлээ.

Улсын нэр	Зээлийн хүүгийн дээд хэмжээ тогтоосон эсэх	Зээлийн хүүгийн дээд хэмжээний хамрах хүрээ	Хариуцлага
1.БНСУ	8 дугаар зүйл Зээлдүүлэгчийн хувь хүн болон Жижиг, дунд аж ахуй нэгжийн үйл ажиллагааны тухай хуулийн 2.2-т тодорхойлсон жижиг корпорацид олгох зээлийн хүү Ерөнхийлөгчийн зарлигт заасан хэмжээнээс ихгүй буюу жилийн 27.9 хувиас хэтрэхгүй байна.	Банк, банк бус санхүүгийн байгууллагууд,, Хадгаламж, зээлийн хоршооноос олгох зээлийн болон хувь хүн, жижиг дунд үйлдвэр эрхлэгчид зээл олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчийн зээлийн хүүгийн	8.3 дугаар зүйл Зээлдүүлэгч нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасныг зөрчиж зээлийн гэрээ байгуулсан бол энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүүгийн хэмжээнээс хэтэрсэн хүүгийн хэмжээ хүчин төгөлдөр бус байна. 8.4 дүгээр зүйл Зээлдэгч нь энэ хуулийн 1 дэх хэсэгт заасан хүүгийн хэмжээнээс хэтрүүлэн хүү төлсөн бол илүү төлсөн дүнг

	11 дүгээр зүйл Бүртгэлгүй зээлдүүлэгчээс олгох зээлийн хүүгийн хэмжээнд Зээлийн хүүгийн хэмжээнд хязгаарлалт тогтоох тухай хуулийн 2(1) дүгээр зүйл болон энэ хуулийн 8 (2)-(5) дугаар зүйл нэгэн адил үйлчилнэ. 3 дугаар зүйл Зээлийн санхүүгийн байгууллагаас олгох зээлийн хүү Ерөнхийлөгчийн зарлигт тусгасан хэмжээнээс ихгүй буюу жилийн 27.9 хувиас хэтрэхгүй байна.	хэмжээнд дээд хязгаар тогтоосон. 8.2 дахь заалт Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүүгийн хэмжээг тодорхойлоход зээлтэй холбоотойгоор зээлдүүлэгчийн авсан бүх төлбөрийг төлбөрийн нэршлээс үл хамааран хүү гэж тооцно. (Үүнд төлбөр, хураамж, урамшуулал, хөнгөлөлт, нэмэгдүүлсэн хүү, орлуулах төлбөр гэх мэт)	үндсэн зээлийн төлбөрт тооцон суутгана. Ийнхүү үндсэн зээлийн төлбөрийг бүрэн суутгасны дараа үлдэгдэл дүн гарч байвал зээлдэгч нь үлдэгдлийг шаардах эрхтэй. 19.2.3 дахь заалт Энэ хуулийн 8 эсхүл 11(1) дэх заалтад заасан хэмжээнээс хэтрүүлэн зээлийн хүүгийн хэмжээг тогтоосон этгээдэд 3 хүртэлх жилийн хорих ял эсхүл 30 сая хүртэлх воноор торгох шийтгэл ногдуулна.
2.Япон	Зээлийн хүүнд хязгаарлалт тогтоох тухай хуулийн 1-р зүйл. Хэрэв зээлийн гэрээний хүүгийн хэмжээ дор дурдсанаас хэтэрсэн бол Хэтэрсэн хүүгийн хэмжээг үндэслэн тооцсон дүн нь хүчингүй байна. (i) үндсэн зээлийн хэмжээ 100,000 иенээс бага бол: жилийн 20 хувь; (ii) үндсэн зээлийн хэмжээ 100,000 иен ба түүнээс дээш боловч 1,000,000 иенээс бага бол: жилийн 18 хувь; эсвэл (iii) үндсэн зээлийн хэмжээ 1,000,000 иен ба түүнээс дээш	3 дугаар зүйл. Өмнөх хоёр заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Зээлдүүлэгчийн үндсэн зээл авсан урамшуулал, хөнгөлөлтийн хураамж, шимтгэлийн хураамж, хяналт шалгалтын хураамж эсвэл бусад нэрээр зээлтэй холбоотой авсан мөнгийг хүү гэж тооцно; гэвч энэ нь гэрээ байгуулах, үүргийн гүйцэтгэлд оруулсан зардалд хамаарахгүй	47 дугаар зүйлийн 47.3 дугаар зүйлд зааснаар 10 жилээс ихгүй хугацаагаар хөдөлмөрлөн хорих эсвэл 30 сая иенээс ихгүй хэмжээгээр торгох.

	бол: жилийн 15 хувь. Зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 12.8 Дээрх хуульд заасан хэмжээгээр хүү тооцно.	болно.	
3.Малайз	17.1 дүгээр зүйл Энэ хуулиар тогтоосон журмаар тодорхойлсон хүүгийн хэмжээнд барьцаалан зээлдэх үйл ажиллагаа явуулна. Хэтэрсэн хэмжээгээр хүү авахыг хориглоно.		17.2 дугаар зүйл зөрчвөл хариуцлага хүлээнэ. 41а зүйл Зөрчилд 100 мянган рингитээр торгох, эсхүл 6 сар хүртэлх хугацаагаар хорих, эсхүл хамтад нь ногдуулна.
	17А. (1) Энэ хуульд заасны дагуу баталгаат зээлийн хүү жилийн 12 хувиас хэтрэхгүй, баталгаагүй зээлийн хүү жилийн 18 хувиас хэтрэхгүй байна.	17(1) Хүүгээ өсгөх, эсвэл нийлмэл хүү тооцвол гэрээ нь хууль бус байна.	17А.3 Зээлийн хүүгийн хэмжээг хэтрүүлэн гэрээ байгуулсан бол гэрээ нь хүчин төгөлдөр бус, хэрэгжих боломжгүй байна. 17А.4 Зөрчсөн тохиолдолд 2000 хүртэл рингитээр торгох, эсхүл 18 сар хүртэлх хугацаагаар хорих, эсхүл хамтад нь шийтгэнэ.

4.Сингапур	50 дугаар зүйл (1) Ломбард барьцаалан зээлдүүлэх газар хоёрдугаар хавсралтын дагуу зөвшөөрөгдсөн ашиг, төлбөрөөс бусад төлбөр авах ёсгүй. (2) Зээлийн гэрээ нь хоёрдугаар хавсралтын дагуу зөвшөөрөгдсөнөөс бусад төлбөр ашиг авсан тохиолдолд хэтэрсэн хэмжээгээр хүчин төгөлдөр бус байна.	Хоёрдугаар хавсралт Барьцаалан зээлдүүлсэн газрын ашиг дараах хэмжээнээс хэтрэхгүй байх ёстой - (а) зээлийн сар тутамд зээлийн нийт дүнгийн 1.5%; ба (b) зээлийн хугацааг бүтэн саруудад хуваах боломжгүй бол зээлийн нийт дүнгийн 1.5% -ийг сарын хэсэг болгон авах боломжтой хугацаанд 2.Ломбард нь зээлийн хугацаа дууссанаас хойш 2 сарын дараа зээлээс ямар нэгэн ашиг авахгүй, үргэлжлүүлэн авах ёсгүй. 3. 67-р хэсгийн дагуу мэдэгдэл хийсний дараа ломбард барьцаалагчтай барьцаалахаас татгалзсан аливаа хугацаанд ямар ч ашиг олж болохгүй. 4. Ломбард дараахь төлбөрийг төлнө. (а) барьцаалан зээл авах эрхтэй боловч ломбардны билетгүй гэж байгаа этгээдээс	50 (3) 50.1-ийг зөрчсөн ломбард гэм буруутай байна. 79 дүгээр зүйл 20,000 доллар хүртэлх хэмжээгээр торгох, эсхүл 12 сар хүртэлх хугацаагаар хорих эсвэл хамтад нь шийтгэнэ.
------------	--	---	--

		өгсөн 66 дугаар зүйлийн дагуу өргөдөл гаргахад - \$ 10; (б) барааны хууль ёсны өмчлөгчид буруу барьцаалсан гэж гомдол гаргасан этгээдийн 67-р зүйлийн дагуу мэдэгдэл хийхэд - \$ 10.	
	22 А Зээлийн хүүгийн дээд хэмжээнээс хэтэрсэн гэрээ байгуулахыг хориглоно. Зээлийн хүүгийн дээд хэмжээг Сайдаас тогтооно. (төрөл, зээлдэгчийн онцлогоор өөр өөр зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтооно) Хэрэв хэтэрсэн хүүтэй зээлийн гэрээ байгуулбал гэрээ нь хүчингүй, хэрэгжих боломжгүй байна. Ийм гэрээнд баталгаа, барьцааг хангах эрхгүй. Хэрэв ийнхүү мөнгө зээлсэн бол шүүхийн журмаар үндсэн зээлээ авах эрхгүй.		22.А (4) 20,000 хүртэл доллараар торгох, эсхүл 6 сар хүртэл хугацаагаар хорих, эсхүл хамтад нь шийтгэнэ.
5.Эстони	52 дугаар зүйл Хэрэглээний зээлийн гэрээ байгуулахдаа зээлдүүлэгч эсвэл зээлийн зуучлагч дараахь зүйлийг баталгаажуулна. 1) зээлийн хүүг тооцоход ашигласан индекс эсвэл		95 дугаар зүйл Хувь хүн бол эхний удаад 1,200 евро хүртэл торгох, 6000 евро хүртэл Хуулийн этгээд бол эхний үйлдэлд 3200 евро хүртэл торгох, удаахаас 52,000 евро хүртэл торгоно.

	хүүгийн хэмжээг зээлийн гэрээний тал болон Санхүүгийн хяналт эрх бүхий байгууллага нь тодорхой, хэрэглэх боломжтой, бодитой бөгөөд шалгаж болохоор байх; 2) хүү тооцоход ашигласан индексийг хөрвүүлэгч буюу зээлдүүлэгч нь энэ актад заасан шаардлагад нийцүүлэн индексжүүлсэн хувь эсвэл хүүгийн түвшингийн талаар өмнөх үеүүдийн мэдээллээр хангах.		
6. Гүрж	Зээлийн хүүгийн дээд хэмжээ тогтоогоогүй.		
7.Ирланд	20.1 дүгээр зүйл Барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагааны зээлийн хүүгийн дээд хэмжээ хавсралт 5-д заасан хэмжээтэй байна. Зээлдүүлэгч энэ хэмжээгээр хүүг авна.		20.(1) 4 Илүү хэмжээгээр хүү авбал зөрчилд тооцогдоно.
	10.7 Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч жилийн хүүг тооцох энэ хуульд заасан аргачлалын дагуу хүү тооцно.		13 дугаар зүйл Зөрчвөл 50,000 доллар хүртэл хэмжээгээр торгох, эсхүл 5 жил хүртэл хугацаагаар хорих. Дахин үйлдвэл өдөр бүрээр торгуультай.
8.Канад	28 дугаар зүйл Хууль ёсны зээлийн хүүгийн хэмжээнд хүү авна	Тасалбарт 20 цент; Барьцаа хадгалалтад 1 кубд 1 сард 10	29 дүгээр зүйл 2000 хүртэл доллараар торгоно.

		аас ихгүй цент; Тасалбарыг хувилахад 20 центеес ихгүй төлбөр авч болно.	
9.Намибия	22 дугаар зүйл Бүртгэгчийн тогтоосон зээлийн хүүгийн дээд хэмжээнээс хэтэрсэн хэмжээгээр зээлийн хүү авч болохгүй.		22.3 дугаар зүйл N500,000-аас хэтрэхгүй хэмжээгээр торгох, эсхүл 5 жил хүртэл хугацаагаар хорих, эсвхүл хамтад нь шийтгэнэ.
10.Ямайка	46 дугаар зүйл Зээлдүүлэгчийн хүүгийн хэмжээ ЗГ- ын богино хэмжээний зээлийн хүүтэй холбоотой байна. Зээлдэгчийн эрсдэлийг үнэлсэний үндсэн дээр тогтооно. Хүү бодолтыг зээлдэгчид бичгээр өгнө. Хугацаа хожимдуулсны төлбөрийг үндсэн зээлээс бус, төлөөгүй дүнд хамааруулан тооцно.		46 дугаар зүйл Зээлдүүлэгчийн хүүгийн хэмжээ ЗГ-ын богино хэмжээний зээлийн хүүтэй холбоотой байна. Зээлдэгчийн эрсдэлийг үнэлсний үндсэн дээр тогтооно. Хүү бодолтыг зээлдэгчид бичгээр өгнө. Хугацаа хожимдуулсны төлбөрийг үндсэн зээлээс бус, төлөөгүй дүнд хамааруулан тооцно.

Судалгаанд хамрагдсан улсуудад зээлийн хүүгийн дээд хэмжээг хуулиар тогтоосон, эсхүл холбогдох сайд болон тусгай зөвшөөрлийн бүртгэл хийсэн байгууллага тогтоохоор заасан байна.

Зээлийн хүүгийн дээд хэмжээнээс хэтэрсэн хэмжээний хүүтэй зээл олговол илүү төлсөн хэсгээр хүчингүй байх, давхар хуулийн хариуцлага ногдуулахаар заасан байна. Хуулийн хариуцлагын хувьд нийтлэг байдлаар торгох болоо хорих ял шийтгэлтэй байна.

Малайз Улсын хувьд баталгаат зээлийн хүү, баталгаагүй зээлийн хүүгийн хэмжээг ялгамжтай тогтоосон байна.

Солонгос Улсын хувьд хувь хүн, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчээс олгох зээл болон банк санхүүгийн байгууллагаас олгох зээлийн хүүгийн хэмжээг мөн адил тус хуулиар тогтоосон байна.

Сингапур Улсын хувьд сайдын тогтоосон зээлийн хүүгийн дээд хэмжээнээс хэтрүүлж зээлийн хүү тооцсон зээл олговол гэрээ бүхэлдээ хүчингүй байх, мөн хуулийн хариуцлага хүлээх хатуу зохицуулалт байна.

Солонгос, Япон улсуудын хувьд нэмэгдэл хүү, төлбөр, хураамж нэршлээс үл хамааран хүүгийн жилийн дээд хэмжээг тогтоосон байна. Өөрөөр хэлбэл нэмэлт хүү, төлбөр авахыг хориглосон байна.

7.БАРЬЦАА, ҮНЭЛГЭЭ

Малайз, Сингапур, Ирланд, Канад улсууд **Pawnbrokers act** буюу **Барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагааны тухай** бие даасан хуультай. Эдгээр улсуудын ломбардын хуульд барьцаа, барьцаа хөрөнгийн үнэлгээний асуудлыг хэрхэн зохицуулсныг доор авч үзье.

	Малайз	Сингапур	Ирланд	Канад
Хориглолт	16 дугаар зүйл 18.00-08.00 цагийн хооронд, 18 насанд хүрээгүй хүнд, мансуурсан, эсхүл сэтгэц мэдрэлийн өвчтэй, төрийн өмчийн тэмдэг, шошготой эд хөрөнгө, өөр хүний эд зүйлийг зөвшөөрөлгүйгээр барьцаанд тавих гэж байна гэсэн үндэслэл бүхий сэрдэх үндэслэл байсан бол барьцаанд эд зүйл авахыг хориглоно.		19 дүгээр зүйл 16 насанд хүрээгүй, мансуурсан, архинаас хамааралтай этгээд, барьцааг худалдаж авах, зарах, барьцаанд авах ажлыг 16 наснаас доош этгээдээр хийлгэх, энэ хуульд зааснаас өөр байдлаар дуудлага худалдаа явуулах, сэжиг бүхий эд зүйлсийг барьцаанд	8 дугаар зүйл 18 насанд хүрээгүй, архи, мансууруулах бодис хэрэглэсэн, бусад зээлдүүлэгч болон өөрийнхөө барьцаалсан эд хөрөнгийг буцааж авах, худалдан авах, өглөө 8 цагаас өмнө, оройн 8 цагаас хойш, ням гариг, засаг даргын тогтоосон өдөр, барьцаанд байх үед зарах, ашиглах,

			авах, галт зэвсэг барьцаанд авах хориотой.	медаль, тэмдэг (Хааны), үнэт эдлэлийг хайлуулах (барьцаанд байх үед)
Барьцааны хугацаа	18, 19 дүгээр зүйл 6 сар ба тохиролцсон өөр хугацаа 3 сар хүртэлх хугацаагаар сунгаж болно.	54 дүгээр зүйл 6 сар ба түүнээс илүү хугацаагаар талууд тохиролцож болно. 55 дугаар зүйл Нэг болон түүнээс дээш удаа сунгагдаж болно. Барьцааны хугацаа дууссан боловч сунгаж болно.	21 дүгээр зүйл 6 сар болон 6 сар хүртэлх хугацаагаар сунгаж болно (хэрэв хүүгээ төлсөн бол) Үнэт эдлэлийн хувьд 1 жил байх боломжтой.	21-23 дугаар зүйл 1 жил
Сэжигтэй байж болох эд зүйлийн талаар орон нутаг болон цагдаад мэдээлэх	20 дугаар зүйл 31.2 дугаар зүйл	-	37 дугаар зүйл	11 дүгээр зүйл
Үнэлгээ	22 дугаар зүйл Барьцаанд тавьсан эд зүйл гэмтэх, эд зүйлд хохирол учирвал зээлдүүлэгч хариуцна. Хохирлын нөхөн төлбөрийн хэмжээ нь зээлийн дүнгээс	48 дугаар зүйл Үнэлгээ хийсний дараа гэрээ байгуулна. Үнэлгээ хийлгүй гэрээ байгуулсан бол хүчин	40, 41 дүгээр зүйл Зохистой байдлаар барьцаанд тавьсан эд зүйлийг хадгалах, эргүүлэн өгөх, хариуцах, галд гэмтэж,	26 дугаар зүйл Нөхөн төлөх, эсхүл төлөх ёстой төлбөрөөс хасах.

	4-ний 1 дахин их байна. 25 дугаар зүйл Барьцаа зарж борлуулсан бол илүү гарсан хэсгийг буцааж өгөх.	төгөлдөр бус байна. 60 дугаар зүйл Анх үнэлгээ хийлгэсэн байдлаар нь өгөх боломжгүй болсон тохиолдолд үнэлгээ хийлгэхэд байсан байдлаар нөхөн төлнө. 65 дугаар зүйл Үнэлгээ нь авсан зээл, төлөх хүүгээс хэтэрсэн бол илүү хэсгийг барьцаалуулагчид төлөх.	хохирол учирвал барьцаалуул агчид нөхөн төлөх.	
--	--	--	---	--

Барьцааны хугацааны дээд хэмжээг тогтоож өгсөн байна. Энэ хугацаанд сунгах боломжтой. Түүнчлэн үнэлгээ анх заавал хийх, үнэлгээ хийгээгүй барьцаалан зээлдсэн бол гэрээ хүчингүй байх, барьцааны зүйлийг үнэлгээнд дурдсан байдлаар хүлээлгэн өгөх, зарж борлуулсан бол акт үйлдэж зөрүү мөнгийг буцаах, хохирол учирч барьцааны зүйл эвдэрсэн, гэмтсэн, алга болсон бол зээлдүүлэгч өөрөө хариуцах талаар нийтлэг байдлаар зохицуулжээ.

8.БҮРТГЭЛТЭЙ ЭТГЭЭДИЙН ҮҮРЭГ

Улс орнууд тус бүрийн хууль тогтоомжиндоо тусгай зөвшөөрөл бүхий этгээдэд дараах нийтлэг үүргийг хүлээлгэсэн буюу зөрчвөл хуульд заасан хариуцлага ногдуулахаар байх тул дор эдгээр үүргүүдийг түүвэрлэлээ.

ХУУЛЬД ЗААСАН ҮҮРЭГ	Малайз улсын барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагааны тухай хууль
----------------------------	--

Тусгай зөвшөөрлөө ил харагдах газар байршуулах	10C 16(2)
Нэг байршилд үйл ажиллагаагаа явуулах	
Үйл ажиллагаа явуулах байршилд өөр үйл ажиллагаа явуулахгүй байх	16(3)
Зээлийн үйл ажиллагаанаас өөр үйл ажиллагаа эрхлэхийг хориглох	
Тусгай зөвшөөрлийн нөхцөл өөрчлөгдөх, нэмэгдэх, хасагдах, түүнийг дагаж мөрдөх	10 A
Үйл ажиллагаагаа эрхлэхээ зогсоосон бол зээлдэгч нар болон бүртгэгчид барьцааны тоо баримтын талаар мэдээлэх	11(G)
Тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан боловч барьцааг чөлөөлөх болон барьцаат хугацаа дуусах хүртэл нээлттэй байх	12(1)
Данс, тооцоо, зээлийн гэрээний бүртгэл баримт бичгийг эрх бүхий байгууллагад хүргүүлэх	13(A)
Гэрээний эх хувийг хадгалах	18
Барьцаалсан зүйлс, барьцааны тасалбар, барьцаалуулагчийн мэдээллийг тусгах дэвтэр хөтлөх	14.1
Барьцаалсан эд зүйлсийг зөвшөөрөлтэй барйшилд хадгалах, түүнээс өөр газар гэрээ хэлцэл хийхгүй байх	16.2
Хулгайн болон сэжигтэй зүйлийн талаар цагдаад мэдэгдэх	20.1
Тасалбар алга болсон тохиолдолд хувилж өгөх	21
Барьцааны эд зүйлс алга болох, гэмтэхэд барьцаалан зээлдүүлэх газар хариуцлага хүлээх	22.2

ХУУЛЬД ЗААСАН ҮҮРЭГ	Сингапур улсын барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагааны тухай хууль
Зээлийн хүүгийн дээд хэмжээ болон авах төлбөрийг ил харагдах байдлаар байршуулна.	22.2
Барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа, түүний гэрээ хэлцэлийг хадгалах, хүргүүлэх.	23
Жилийн аудит хийлгэх.	25
Заавал даатгуулсан байх, баталгаа байршуулах.	26, 27

Голлох хувьцаа эзэмшигч шаардлага хангахгүй болсон тохиолдолд мэдэгдэх	28
Байршилд барьцааны гэрээ байгуулж хадгалах, байршилд өөр үйл ажиллагаа явуулахгүй байх	21
Терроризмыг санхүүжүүлэх, мөнгө угаахын эсрэг арга хэмжээ авч хэрэгжүүлэх	74

ХУУЛЬД ЗААСАН ҮҮРЭГ	БНСУ-ын зээлийн үйл ажиллагааны тухай хууль
Хуурамч хэтрүүлэгтэй сурталчилгаа хийхийг хориглох	9-2
Үйл ажиллагаандаа мөрдөх үндсэн дүрэм, журам, стандарт тогтоох, хяналтын ажилтан томилох	9-7
Зээлийн үйл ажиллагааны талаар сургалтад хамрагдах	3-4
Бүртгэлд өөрчлөлт оруулах бол мэдэгдэх	5-1
Үйл ажиллагаагаа бүр мөсөн зогсоох болон хаах бол мэдэгдэх	5-2
Салбар бүрт ерөнхий менежер томилох	5-3
Зээлийн гэрээ байгуулах тусгах нөхцөлүүд (хуульд заасан)	6
Эргэн төлөлт хийх дансны дугаар	6.1.6
Төлбөрийн чадвараас давсан зээл олгохыг хориглох	7.2
Нийт хөрөнгөд тавих хязгаарлалт	7-3

ХУУЛЬД ЗААСАН ҮҮРЭГ	Гүрж улсын бичил зээлийн үйл ажиллагааны тухай хууль
Санхүү, татварын тайлан мэдүүлэх	8 дугаар зүйл
Дотоод удирдлагын баримт бичиг баталж мөрдүүлэх	
Жил бүр гадаад аудитаар шалгуулах	

Нягтлан бодох бүртгэлийн тайлангаа мэдүүлэх	
Төв банкинд санхүүгийн мэдэгдэл хүргүүлэх	
Мэдэгдэлд оруулсан мэдээллийн үнэн зөвийг хангах	
Санхүүгийн мэдэгдэл, аудитын тайланг олон нийтэд мэдэгдэх	
6 жилийн хугацаанд санхүүгийн тайлан, зохион байгуулалтын баримт бичиг, дансны дэвтэр хадгалах	

ХУУЛЬД ЗААСАН ҮҮРЭГ	Канад улсын барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагааны тухай хууль
Нэг этгээд нэг тусгай зөвшөөрлөөр нэгээс илүү барьцаалан зээлдүүлэх газарт үйл ажиллагаа явуулахгүй	4 дүгээр зүйл
Орон нутгийн байгууллагадаа баталгаа өгөх	6 дугаар зүйл
Зээлийн хүүгийн хэмжээг харуулсан пайз байршуулах	7 дугаар зүйл
Барьцааны гэрээний дэвтэр хөтлөх	9 дүгээр зүйл
Барьцааны дэвтэрт барьцааг дугаарлан бүртгэнэ	9.3
Сэжигтэй болон хулгайн эд зүйлийн талаар цагдаа болон орон нутгийн байгууллагад мэдэгдэх	11 дүгээр зүйл
Жилээс багагүй хугацааны барьцаалуулагч нарын мэдээллийг цагаан толгойн үсгийн дарааллаар бүртгэх	12 дугаар зүйл
Өдөр бүр цагдаад мэдээлэх (өмнөх өдрийн бүх гэрээ, барьцааны талаар)	13 дугаар зүйл

ХУУЛЬД ЗААСАН ҮҮРЭГ	Ирланд улсын барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагааны тухай хууль
Зээлийн хүүгийн хэмжээ, бусад төлбөр, барьцааны талаарх нөхцөлийг байршуулах	13 дугаар зүйл
Барьцааны бүртгэл, барьцаа худалдааны бүртгэлийг хадгалах	16 дугаар зүйл
16 насанд хүрээгүй этгээдэд зээл өгөхгүй байх	19 дүгээр зүйл
Мансуурсан болон согтуурсан хүнд зээл өгөхгүй байх	
Барьцааны зүйл худалдан авахгүй байх	
Барьцаат хугацаанд барьцааны эд зүйлийг худалдах, худалдан авах тохиролцоо хийхгүй байх	
Сэжиг бүхий эд зүйл барьцаанд авахгүй байх	
Хуульд зааснаас өөр байдлаар барьцааны хөрөнгийг зарж борлуулахгүй байх	

Сэжиг бүхий эд зүйлийн талаар мэдээлэх	37 дугаар зүйл
Тусгай зөвшөөрөл бүхий газарт зохих ёсоор барьцааны хөрөнгийг хадгалах	40 дүгээр зүйл
Барьцаанд авсан зүйл галаас болж устсан, гэмтсэн бол нөхөн төлөх	41 дүгээр зүйл

ХУУЛЬД ЗААСАН ҮҮРЭГ	Эстони улсын зээлийн үйл ажиллагааны тухай хууль
Дотоод дүрэм журам батлах	44 дүгээр зүйл
Хэрэглэгчийн зээлийн төлбөрийн чадварыг үнэлэхэд өгөгдлийг ашиглахын тулд зээлдүүлэгч эсвэл зээлийн зуучлагч санхүүгийн үүргийн хэмжээ, хэрэглэгчийн төлбөрийн үүргийн гүйцэтгэлийн талаархи мэдээллийг хадгалах шаардлагатай.	47 дугаар зүйл
3 жилийн хугацаанд зээлийн мэдээллийг хадгалах, Санхүүгийн зохицуулах хороонд тус мэдээлэлд нэвтрэх боломжийг олгох	
Хэрэглэгч тус бүрээр зээлийн хавтас хадгалах	48 дугаар зүйл
Аудитын тайлан, жилийн тайлан , хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, ашиг хувиарлах талаар мэдээлэх	56 дугаар зүйл
Тайлан улирал бүр хүргүүлэх	57 дугаар зүйл
Жил бүр аудит хийлгэх	59 дүгээр зүйл

ХУУЛЬД ЗААСАН ҮҮРЭГ	Япон улсын зээлийн үйл ажиллагааны тухай хууль
Зээлдүүлэгчээс зээл нэхэхэд хориглох арга замуудыг хуульчилсан байна	21 дүгээр зүйл
Журамд заасан мэдээллийг агуулсан пайзыг үйл ажиллагаа явуулж буй газар бүртээ байлгах	23 дугаар зүйл
Үйл ажиллагаагаа эхлүүлсэн, түдгэлзүүлсэн асуудлаа мэдэгдэх	24 дүгээр зүйл
Бүртгэлийн дэвтэр хадгалах, мэдээлэх	24 дүгээр зүйл

ХУУЛЬД ЗААСАН ҮҮРЭГ	Намибиа улсын бичил зээлийн үйл ажиллагааны тухай хууль
----------------------------	---

Тусгай зөвшөөрөлд заасан байранд зээлийн үйл ажиллагаанаас өөр үйл ажиллагаа эрхлэхээр бол мэдэгдэж зөвшөөрөл авах	20 дугаар зүйл
Зөвшөөрөл авалгүйгээр шинэ салбар нээхийг хориглоно	21 дүгээр зүйл
Зээлдэгчээс зээлийг нэхэхдээ хууль бусаар харилцаж болохгүй.	23 дугаар зүйл
Намибиа улсад бүртгэлгүй аргаар төлбөр гүйцэтгэх	
Мөнгөн зээлийн үйл ажиллагааны хуулийн хуулбарыг хадгалах	24 дүгээр зүйл
Гомдол гаргах журмыг бэлэн байлгах, постер дээр байршуулах	
Зээлийн хүүгийн дээд хэмжээг байршуулах	

ХУУЛЬД ЗААСАН ҮҮРЭГ	Ямайка улсын зээлийн үйл ажиллагааны тухай хууль
Зээлийн гэрээний нөхцөлийн талаар буруу ташаа мэдээллээр зар сурталчилгаа явуулах	50 дугаар зүйл
Тусгай зөвшөөрлөө үйл ажиллагаа явуулж буй байршилд байршуулах	12 дугаар зүйл
Байршлаа мэдэгдэж батлуулалгүйгээр солихгүй	20 дугаар зүйл
Мэдэгдэлгүйгээр үүсгэн байгуулах баримт бичгийг өөрчлөхгүй	22 дугаар зүйл
Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь зөвхөн зээлийн үйл ажиллагаа явуулна	31 дүгээр зүйл

Ямайка, Малайз зэрэг улсад тусгай зөвшөөрлөө ил харагдах газар үйл ажиллагаагаа эрхэлж буй газар байршуулах шаардлагыг зээлдүүлэгчид тавьдаг бол ийм байдлаар пайз тавихдаа зээлийн хүүгийн дээд хэмжээг мөн байршуулахыг шаарддаг Сингапур, Канад, Ирланд, Япон, Намибиа зэрэг улсууд байна.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч зөвхөн зээлийн үйл ажиллагаа эрхлэнэ гэж тодотгосон улсууд Ямайка, Малайз, Ирланд Улс байна.

Байршлаа солих бол мэдэгдэж батлуулах, тусгай зөвшөөрөлд дурдсан байршилдаа үйл ажиллагаа явуулах үүргийг нийтлэг байдлаар хуульчилсан байна.

Гэрээ, хэлцлийг тодорхой хугацаанд хадгалах ерөнхий үүрэг байна.

Барьцааны бүртгэлийн дэвтэр хөтлөх үүрэг мөн нийтлэг байдлаар байна.

Түүнчлэн сэжигтэй болон хулгайн эд зүйлийн талаар цагдаад мэдэгдэх, жил бүр аудит хийлгэх үүрэг нийтлэг байдлаар байна.

Намибиа, Япон зэрэг улсад зээлдэгчээс өр төлбөр нэхэхдээ зохисгүй харилцахыг хориглосон байна.

9.БҮРТГЭЛГҮЙ ЭТГЭЭДИЙН ХАРИУЦЛАГА

Энэ хүрээнд бүртгэл, тусгай зөвшөөрөлгүйгээр мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхэлсэн иргэн, хуулийн этгээдэд ямар хариуцлага оногдуулахаар улс орнуудын хууль тогтоомжид тусгасныг танилцуулж байна.

	Улсууд	Бүртгэлгүй этгээдээс олгох зээлийн үйл ажиллагааг хориглосон эсэх	Түүнд оногдуулах хариуцлага
1.	БНСУ	11 дүгээр зүйл Бүртгэлгүй зээлдүүлэгчийн зээлийн хүүгийн хэмжээнд энэ хуульд заасан хязгаарлалт нэгэн адил хамаарна.	19.1.1 Энэ хуулийн 3 эсхүл 3-2 дугаар зүйлийг зөрчиж, бүртгэлд бүртгүүлэхгүйгээр эсхүл бүртгэлийн хугацааг сунгуулалгүйгээр зээлийн үйл ажиллагаа эрхэлсэн этгээдэд 5 хүртэлх жилийн хорих ял, эсхүл 50 сая хүртэлх воноор торгох шийтгэл ногдуулна.
2.	Япон	Бүртгэлгүй этгээд зээлийн үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Зээл олгох болон зар сурталчилгаа явуулах 11 дүгээр зүйл	47 дугаар зүйл 10 аас доош жилээр хорих эсхүл, 30 сая вон хүртэл торгох, аль эсвэл хамтад нь
3.	Малайз	7 дугаар зүйл Хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөлгүйгээр хэн ч барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.	7 дугаар зүйл Хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөлгүйгээр, эсвэл тусгай зөвшөөрлийн хугацаа нь дууссан, түдгэлзүүлсэн, хүчингүй болгосны дараа үйл ажиллагаа явуулсан бол 2000-100,000 рингитээр торгох эсвэл 5 жил хүртэлх хугацаагаар хорих, эсвэл хоёр дахь удаагаа ингэвэл эдгээр шийтгэлийг хамтад нь хэрэглэнэ. Мөн давхар тухайн этгээдийн үйл ажиллагаа явуулах эрхийг хасна.
		5.1 дүгээр зүйл Хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөлгүйгээр хэн ч зээлийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.	5.2 дугаар зүйл Хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөлгүйгээр, эсвэл тусгай зөвшөөрлийн хугацаа нь дууссан, түдгэлзүүлсэн, хүчингүй болгосны дараа үйл ажиллагаа явуулсан бол 2500- 1 сая рингитээр торгох эсвэл 5 жил хүртэлх хугацаагаар хорих, эсхүл хоёр дахь удаагаа хууль зөрчвөл эдгээр шийтгэлийг хамтад нь хэрэглэнэ. Мөн

			давхар тухайн этгээдийн үйл ажиллагаа явуулах эрхийг хасна. 15 дугаар зүйл Бүртгэлгүй этгээдийн байгуулсан мөнгөн зээлийн гэрээ хүчин төгөлдөр хэрэгжихгүй.
4.	Сингапур	6 дугаар зүйл Тусгай зөвшөөрөлтэйгээр барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа явуулна.	6.3 дугаар зүйл Хэрэв зөрчсөн бол урьд өмнө нь ял шийтгэлгүй бол 50,000 доллараас ихгүй хэмжээгээр торгох; Хэрэв урьд нь ял шийтгүүлж байсан бол 50,000 доллараас ихгүй хэмжээгээр торгох, эсхүл 12 сар хүртэл хугацаагаар торгох, эсвэл хамтад нь ял шийтгэнэ.
		5 дугаар зүйл Хэн ч Сингапур улсад тусгай зөвшөөрөлгүйгээр мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.	14.(1) А Хуулийн этгээд бол 50,000-500,000 доллар хүртэл хэмжээгээр торгох. 14.(1) Б Бусад тохиолдолд 30,000-300,000 доллар хүртэл хэмжээгээр торгох, эсхүл 4 жилээс хэтрэхгүй хугацаагаар хорих. Давтан үйлдсэн тохиолдолд 30,000-300,000 доллараар торгох, эсхүл 7 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
5.	Эстони	-	
6.	Гүрж	-	
7.	Ирланд	7 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөлгүйгээр аливаа байршилд барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа явуулахыг хориглоно.	7.3 дугаар зүйл Зөрчлийн хариуцлага хүлээнэ.
		98 дугаар зүйл Тусгай зөвшөөрөлгүйгээр мөнгөн зээлийн үйл ажиллагаа явуулахыг хориглоно.	98.3 дугаар зүйл Үйл ажиллагааг нь зогсоох, мөнгө болон бичиг баримтыг хураан авах, шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.
8.	Канад	2.1 дүгээр зүйл Тусгай зөвшөөрөлгүйгээр	29 дүгээр зүйл 2000 доллараас ихгүй

		барьцаалан зээлдэх үйл ажиллагаа явуулахыг хориглоно.	хэмжээгээр торгоно.
9.	Намибия	3 дугаар зүйл Бүртгэгдээгүй бол мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.	Бүртгэгдээгүй этгээд 4. (1) СЗХ-д энэ хуулийн дагуу эсвэл чөлөөлөх тухай мэдэгдлээр бүртгэгдээгүй байхад аливаа этгээд микрокредит бизнес эрхэлж байна гэж сэжиглэх үндэслэл байгаа бол СЗХ-д 37-р хэсэгт заасан хяналт шалгалтын бүрэн эрхээс гадна. СЗХ нь бичгээр мэдэгдсэнээр тухайн хүнээс СЗХ-д мэдэгдэлд заасан хугацаанд СЗХ-ны бичил зээлийн бизнесийг бүртгүүлэхтэй холбоотой шаардагдах аливаа баримт бичгийн болон бусад мэдээллийн хуулбарыг шаардаж болно. Гаргаж өгөхгүй бол тухайн бизнесийг зээлийн үйл ажиллагаа мөн эсэхийг шалгах данс, мэдээллийг шаардах эрхтэй. 4.3 дугаар зүйл Хэрэв тусгай зөвшөөрөлгүйгээр зээлийн үйл ажиллагаа явуулсан гэж үзвэл дараах арга хэмжээг авна. (а) зээлдэгчид зээл олгохоо зогсоохыг этгээдэд мэдэгдэх; (б) энэ хуулийн заалтуудыг дагаж мөрдөөгүй тохиолдолд Сайдын заасан өдөр тутамд торгууль ногдуулах; ба (в) боломжтой бол алдагдалд орсон зээлдэгчдэд нөхөн олговор олгох замаар энэ актыг зөрчиж байгаа үр нөлөөг арилгах. 3) (b) ба (5) дэд хэсгийг үл харгалзан энэ хэсгийг дагаж мөрдөөгүй аливаа хүн гэмт

			хэрэг үйлдсэн бөгөөд 500 000 доллараас хэтрэхгүй мөнгөөр торгох, эсхүл таван жилээс хэтрэхгүй хугацаагаар хорих ял оногдуулна. Мөн давхар шийтгэл ногдуулж болно.
10.	Ямайка	9 дүгээр зүйл Бичил зээлийн үйл ажиллагаа эрхлэхийг хүссэн этгээд энэ хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөл авна.	9.2 дугаар зүйл Тусгай зөвшөөрөл авалгүй үйл ажиллагаа явуулсан бол хувь хүн бол 500 доллараас ихгүй хэмжээгээр торгох, эсхүл 6 сараас ихгүй хугацаагаар хорих, эсхүл хамтад нь хэрэглэнэ. Хуулийн этгээд бол 1 сая доллараас ихгүй хэмжээгээр торгоно.

Судалгаанд хамрагдсан улсуудын холбогдох хууль тогтоомжоос харахад, барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагааг бүртгэлтэй этгээд гүйцэтгэх, бүртгэлгүйгээр ашгийн төлөө, зээлийн үйл ажиллагааг явуулбал маш өндөр хэмжээний хариуцлага ногдуулахаар заасан байна. Өөрөөр хэлбэл, иргэд хооронд эсвэл ямар ч бүртгэл, хяналт, тусгай зөвшөөрөлгүйгээр зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй компани гэсэн ойлголт байхгүй.

Иргэд болон хуулийн этгээд **жижиг хэмжээний хэрэглээний зээлийн үйл ажиллагаа** явуулахдаа бүртгэл, тусгай зөвшөөрлийн үндсэн дээр явуулахаар зааж, бүртгэлгүй үйл ажиллагаа явуулбал мөн адил өндөр хэмжээний хариуцлага оногдуулахаар заасан байна.

10.БҮРТГЭЛТЭЙ ЭТГЭЭДИЙН ХАРИУЦЛАГА

БНСУ

Дараах үйлдэлд 5 хүртэлх жилийн хорих ял, эсхүл 50 сая хүртэлх воноор торгох шийтгэл ногдуулна.

- Бүртгэлийн хугацаагаа сунгуулалгүйгээр зээлийн үйл ажиллагаа эрхэлсэн этгээд;
- Бүртгэлийн гэрчилгээг хууран мэхлэх аргаар олж авсан;
- Зээлийн үйл ажиллагааг сурталчлахдаа хязгаарлалт зөрчсөн;
- Зээлдэгчийн төлбөрийн чадвараас хэтэрсэн зээл олгох эсхүл зээлдүүлэгчийн их хувьцаа эзэмшигчтэйгээ хийх гүйтгээний нийт хэмжээ өөрийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний 100/100-с хэтэрсэн зээл олгосон, авсан этгээд.

Дараах этгээдэд 3 хүртэлх жилийн хорих ял эсхүл 30 сая хүртэлх воноор торгох шийтгэл ногдуулна.

- Өөрийн нэр дээр зээлийн үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрсөн эсхүл гэрчилгээгээ зээлсэн этгээд;
- Зээлдэгчийн төлбөрийн чадварыг тодорхойлох зорилгоор авсан мэдээллийг өөр зорилгоор ашиглах;
- Зээлийн хүүгийн хэмжээг хэтрүүлэн тогтоосон;
- Бүртгэлгүй зээлдүүлэгчээс зээлийн гэрээний шаардлагыг авсан буюу цуглуулсан;
- Зээлийн санхүүгийн байгууллага тогтоосон хэмжээнээс хэтэрсэн зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүү тооцсоныг арилгуулахаар шаардлага тавихад биелүүлээгүй этгээд.

Дараах тохиолдолд 50 сая хүртэлх воноор торгох захиргааны шийтгэл ногдуулна.

- Бүртгэлд орсон өөрчлөлтийг мэдүүлээгүй;
- Зээлийн үйл ажиллагаа гэсэн үг нэрэндээ ашиглаагүй;
- Зээлийн гэрээнд тусгах нөхцөлүүдийг тусгаагүй, буруу оруулсан;
- Зээлдэгчид зээлийн гэрээний нөхцөл бүрийг тайлбарлаж өгөөгүй;
- Зээлдэгчийн төлбөр төлөх чадварыг тогтоохоор нотлох баримтыг зээлдэгчээс шаардаагүй;
- Гуравдагч этгээдийн өмчлөлийн барьцаа хөрөнгийг тухайн этгээдээр баталгаажуулаагүй;
- Бүртгэлгүй этгээд зар сурталчилгаа явуулсан;
- Худал, бодит байдлыг нуун дарагдуулсан байдлаар зар сурталчилгаа хийсэн;
- Хүчирхийлэлд хариуцлага хүлээлгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн дагуу хорих ялаар шийтгүүлснээс эсхүл хэргийг хэрэгсэхгүй болгосноос хойш 5 жилийн хугацаа өнгөрөөгүй;
- Хийсэн хяналт шалгалтад зохих ёсоор хариулт өгөөгүй эсхүл саад учруулсан;
- Зээлийн тайланг хүргүүлээгүй, хуурамч тайлан хүргүүлсэн, эсхүл тайланд мэдээллийг дутуу оруулсан.

Дараах этгээдэд 10 сая хүртэлх воноор торгох захиргааны шийтгэл ногдуулна.

- Бүртгэлийн гэрчилгээгээ үрэгдүүлсэн, гэсэн тухай мэдэгдээгүй;
- Бүртгэлийг хүчингүй болгосон бол гэрчилгээг буцааж өгөөгүй;
- Гэрээ, баримт бичиг хадгалах үүргээ биелүүлээгүй;
- Хуульд заасан баримт бичгийг хүргүүлэхээс татгалзсан, хуурамч тайлан хүргүүлсэн.

Захиргааны шийтгэлийг Захирагч болон СЗХ ногдуулж, хураана.

Япон

Дараах үйлдэлд 10 хүртэлх жилээр хорих, эсхүл 30 сая иен хүртэлх хэмжээгээр торгох, эсхүл хамтад нь шийтгэнэ.

- Зээлийн хүүгийн хэмжээг хэтрүүлсэн;
- Зээлдэгчийн төлбөрийн чадвараас хэтэрсэн зээл олгох;
- Зээлийн үйл ажиллагаа явуулах байранд зээлийн хүүгийн хэмжээ, эргэн төлөлтийн талаарх мэдээллийг байршуулаагүй;

Түдгэлзүүлсэн хугацаанд үйл ажиллагаа явуулсан бол 5 хүртэлх жилээр хорих, эсхүл 10 сая хүртэлх иенээр торгох.

1 жил хүртэлх хугацаагаар хорих, эсхүл 3 сая хүртэлх иенээр торгох, эсхүл 1 сая хүртэл иенээр торгох зөрчлүүд гэж ангилсан.

Малайз

Барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагааны тухай хуульд хүчингүй болгосон бол бүртгэлийн тусгай зөвшөөрлийг буцааж өгөөгүй, тусгай зөвшөөрлөө бусдад шилжүүлсэн, баримт бичиг, данс, тооцоо хадгалах үүргээ биелүүлээгүй, бүртгэгчид мэдэгдэлгүйгээр зар сурталчилгаа явуулсан, бүртгэлийн дэвтэрт барьцааны эд зүйлийг бүртгээгүй, зээлдэгчид зөв мэдээлэл өгөөгүй, тусгай зөвшөөрөл бүхий газраас өөр газар үйл ажиллагаа явуулсан, зээлийн хүүгийн дээд хэмжээнээс хэтрүүлэн зээл олгосон, сэжигтэй эд зүйл барьцаанд авсан, барьцааны эд зүйлийг зарж борлуулаад илүү гарсан төлбөрийг зээлдэгчид өгөөгүй гэх тохиолдлуудад хорих, эсхүл торгох, зарим тохиолдолд 2 шийтгэлийг хамтад нь хэрэглэхээр заасан байна.

Мөнгөн зээлийн үйл ажиллагааны тухай хуульд зөвшөөрөлгүйгээр зар сурталчилгаа явуулсан, зээлийн тогтоосон хүүг өгсөсөн, эсхүл нийлмэл хүү авсан, барьцаат зээлийн гэрээний хүү, барьцаагүй зээлийн гэрээний хүүг хуульд зааснаас нэмэгдүүлсэн, буруу мэдээлэл зээлийн гэрээнд оруулсан эсхүл хоосон үлдээсэн, зээл олгохын тулд зээлдэгчийг хуурч мэхэлсэн, төөрөгдүүлсэн, зээлдэгчээс зээл нэхэхдээ айлгасан, сүрдүүлсэн, үйл ажиллагаа явуулах байршилдаа тусгай зөвшөөрлөө ил харагдах газар байршуулаагүй, нэрээ солих, менежмент, ажилтнаа томилох, өөрчлөхөөс өмнө мэдэгдээгүй бол торгох, эсхүл хорих шийтгэлтэй.

Сингапур

Сингапурын барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагааны тухай хуульд зааснаар үйл ажиллагаагаа зохих ёсоор, хангалттай байдлаар явуулаагүй, худал мэдээлэл, тайлан гаргаж өгсөн, сэжигтэй эд зүйлийг барьцаанд авсан, 18 насанд хүрээгүй, мансуурсан этгээдээс барьцаанд эд зүйл авсан, цагдаагийн байгууллагаас ирүүлсэн хулгайд алдагдсан зүйлийн жагсаалтанд буй эд зүйлийг барьцаанд авсан, эсхүл барьцаанд тавиулахаар ирсэн үед цагдаад мэдэгдээгүй, терроризмыг санхүүжүүлэх, мөнгө угаахын эсрэг арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй, бэлэн мөнгөний гүйлгээний талаар мэдэгдэх, бүртгэлийн дэвтэрээ 5 жилийн хугацаанд хадгалаагүй гэхчилэн үйлдэлд торгох болон хорих шийтгэл ногдуулахаар байна.

Эстони

Мэдээлэл, тайлангаа өгөөгүй, дотоод журмын шаарлагыг хангаагүй, хэрэглэгчийн зээлийн чадварыг үнэлээгүй, хэрэглэгчийн мэдээллийн нууцлалыг хангаагүй, хөрөнгийг хадгалах шаардлагыг хангаагүй бол торгох шийтгэл ногдуулна.

ХОЁР.ӨДРИЙН ЗЭЭЛ

Өдрийн зээл сарын 10-30 хувийн хүүтэй байдаг. Зарим газар 40 хүртэл хувийн хүүтэй зээл гарч байгаа талаар мэдээлэл байна. Энэ зээлийг худалдаа эрхэлж байгаа бүх хүн авсан гэж хэлэхэд хилсдэхгүй. “Өдрийн зээл” нь барьцаагүй, авахад хялбар байдаг. Ард иргэд хоорондоо “Чамд мөнгө хэрэгтэй юу, надад мөнгө хэрэгтэй. Хэдэн хувийн хүүтэй зээлэх вэ. Уг нь 30 хувийн хүүтэй өгдөг. Гэхдээ яахав чи 10 хувиар авахгүй юу даа” гэх мэтчилэн үүсдэг харилцаа. Өнөөдөр би сая төгрөг 25 хоногийн хугацаатай 10 хувийн хүүтэй авлаа. Маргаашаас нь 44000, 66000 төгрөг төлж эхэлдэг. Авсан зээлийн төлбөрөө 16:00 цагаас өмнө төлөхгүй тохиолдолд 17:00 цагаас хойш цаг тутамд 7000 төгрөгийн алданги тооцож эхэлдэг. Өдрийн зээлээс болж 20 настай бүсгүй амиа хорлосон тохиолдол гарсан.¹⁸

АНУ-ын өдрийн зээлийн талаарх зохицуулалтаас

АНУ-ын 6 муж өдрийн зээлийг хүүгийн хязгаарлалтгүй зөвшөөрсөн, 31 муж 14 өдрийн зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоож, өдрийн зээлийг зөвшөөрсөн, 12 муж өдрийн зээлийг зөвшөөрөөгүй байна.¹⁹

Нарийвчлан тогтоосон нэгэн төрөл хүүгийн хязгаарлалт бол өдрийн зээлд тогтоох хүүгийн хязгаарлалт юм. АНУ-д өдрийн зээл олгох зээлийн хэмжээнд хязгаарлалт тогтоосон байна. 4 өндөр орлоготой улс өдрийн зээлд хүүгийн хэмжээ тогтоосон байна. АНУ-д 30 гаруй муж өдрийн зээлийн хүүгийн хэмжээнд хязгаарлалт тогтоосон байна. Англи улсад өдрийн зээлийн хүү болон төлбөрийн хэмжээг өдрийн 0.8 хувь болгож, зээлсэн мөнгөн дүнгээсээ илүү мөнгө хүү болон төлбөрт төлөхийг хориглон тогтоосон. Канадын эрүүгийн хуулийн дагуу өдрийн зээлийн жилийн хүүгийн хэмжээг 60 хувь болгож хязгаарласан гэхдээ олон мужууд үүнээс доогуур хэмжээ тогтоосон. Австрали улсад мөн өдрийн зээлийг зохицуулж хязгаарлалт тогтоосон байна.²⁰

МУЖ	ЗОХИЦУУЛАЛТЫН АГУУЛГА
Алабама	Өдрийн зээл олгох доод хугацааг 30 хоног болгосон.
Хавай	Өдрийн зээлийн жилийн хүүний хэмжээ 36 хувиас хэтрэхгүй байна
Иллинос	Өдрийн зээлийн жилийн хүүний хэмжээ 36 хувиас доош байна
Индиана	Өдрийн зээлийн жилийн хүүний хэмжээнд дээд хязгаарыг тогтоосон байна.
Кинтаки	Өдрийн зээлийн жилийн хүүний хэмжээ 36 хувиас доош байна, үйлчилгээний хөлсийг байхгүй болгосон.
Мичиган	2500 доллараас их зээлийг өдрийн зээлээр өгөхийг хориглосон байна. Зээл олгосноос хойш 90 хоногоос багагүй хугацаанд төлж болох.
Миннесота	Богино хугацааны жижиг зээлд хүүгийн хэмжээг тусгасан.
Мисисипи	Өдрийн зээл олгохыг хориглосон. Зөрчвөл эрүүгийн хариуцлага хүлээх.
Миссури	Өдрийн зээлийн жилийн хүүгийн хэмжээг 3 оронтой тооноос 36 хувь хүртэл бууруулсан байна. Тус зээлд үйлчилгээний шимтгэл авахыг хориглосон.

¹⁸ <http://dardas.mn/news/view/1254>

¹⁹ Impact of restrictions on interest rates in microfinance ADB sustainable development working paper series 45, 2016

²⁰ World bank Дэлхийн банкны судалгаанаас Interest rate caps The theory and the practice 2018.

Невада	36 хувиас дээш жилийн хүүтэй зээлийг хориглосон. Өндөр хүүтэй зээлийн гэрээ байгуулсан бол хүчингүй байна. Тус үйл ажиллагаа явуулах зээлдүүлэгчид тусгай зөвшөөрөлтэй байх бөгөөд бүртгэлтэй байна. Үйл ажиллагааны стандартыг тогтоосон.
Нью Мехико	Жижиг зээлийн тухай хуулиар жилийн хүүг бууруулсан.
Оклахама	Жижиг зээлийн тухай хууль батлагдсан.
Орегон	Өдрийн зээлийг төлсөнөөс хойш 7 хоног, эсхүл зээлийн хугацаа дууссанаас хойш 7 хоногийн дотор шинээр өдрийн зээл олгож болохгүй.
Роуд Исланд	Өдрийн зээлийн жилийн хүүг бууруулж жилийн 28 хувь болгосон. Доод тал нь 90 хоногийн хугацаатай байхыг шаардана. Үндсэн зээлийн 60 хувиас хэтэрсэн хэмжээний үйлчилгээний шимтгэл болон хүүг нэхэхийг хориглосон.
Хойд Коралина	Өдрийн зээлийг хориглож, эрүүгийн хариуцлага хүлээлгэж байсан. Дараа нь өдрийн зээлийн жилийн хүү 36 хувиас хэтрэхгүй гэж хуульчилсан.
Тэннэси	Өдрийн зээлд хязгаарлалт тавьсан. Зээлдүүлэгч хэлцэл хийхээс өмнө мэдээллийн санд шалгаж, баталгаажуулж хэлцэл хийнэ.
Техас	Өдрийн зээлийн жилийн хүүгийн хэмжээ тогтоосон.
Виржина	(i) хэрэглээний санхүүгийн зээлийн хамгийн бага ба дээд хэмжээг тус тусад нь 500 ба 35,000 доллараар тус тус тогтоосон; (ii) ийм зээлийг зургаан сараас доошгүй хугацаа буюу 120 сараас дээшгүй хугацаагаар олгохыг шаарддаг; (iii) ийм зээлийн жилийн хүүгийн дээд хэмжээг 36 хувь гэж тогтоосон; (iv) гэрээнд заасан тохиолдолд 20 долларын хожимдуулсаны төлбөр авахыг зөвшөөрдөг; (v) 75 доллараас их, эсхүл зээлийн үндсэн дүнгийн таван хувь, гэхдээ 150 доллараас хэтрэхгүй байх зээлийн үйлчилгээний шимтгэл олгохыг зөвшөөрнө.

Канад улсын өдрийн зээлийг зохицуулах тухай хууль 2008²¹

Тус хуулийн дагуу өдрийн зээлийн үйл ажиллагааг эрхлэхийг хүссэн этгээд тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулна. Хэрэв тусгай зөвшөөрөлгүй зээл олговол хүү авах эрхээ алдаж, хуульд заасан хорих эсвэл торгох ял шийтгэлтэй.

Мөн тус хуулийн 31 дүгээр зүйлд зааснаар зээлийн хугацаа дуусах хүртэл урьдчилан төлбөр авахгүй. Зөрчвөл мөн хорих, торгох шийтгэлтэй.

32 дугаар зүйлд зааснаар тогтоосон хугацаанаас илүү хүүтэй зээл олгохгүй. Мөн хуулийн 32.3-т зааснаар сарын хүүгийн дээд хэмжээ 2.5 хувь байхаар тогтоосон байна. Нийлмэл хүү болон аливаа торгууль, нэмэгдүүлсэн хүү авахыг хориглоно. Мөн 33 дугаар зүйлд зааснаар өдөр бүрийн хүү авахгүй болно.

Түүнчлэн өмнөх өдрийн зээлээ төлөөд 7 хоноогүй байхад дахин өдрийн зээл олгохыг хориглоно.

²¹ <https://www.ontario.ca/laws/statute/08p09>

Хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хувь хүн бол 50,000 хүртэлх доллараар торгох, эсхүл 2 жил хүртэлх хугацаагаар хорих, мөн хуулийн этгээд бол 250,000 доллар хүртэлх доллараар торгохоор заасан байна.

САНАЛ, ДҮГНЭЛТ

2016 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай 07 дугаар бүхий Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн дүгнэх хэсгийн 1-д зааснаар “Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр баталсан Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн “ ... 281.3. Зээлийн гэрээ нь хариу төлбөргүй байна.” гэсэн хэсэг нь Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “... өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.”, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтын “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй ...” гэснийг тус тус зөрчсөн байна” гэж, мөн дүгнэх хэсгийн 2-т “Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр баталсан Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар зүйлд “Иргэний хуулийн 282 дугаар зүйл, 283 дугаар зүйлийн 283.2, 283.3, 283.4 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.” гэсэн нь Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “... өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.”, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтын “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна” гэж тус тус дүгнэсэн байна.

2015 оны Иргэний хуулийн нэмэлт, өөрчлөлтийн “Зээлийн гэрээ нь хариу төлбөргүй байна” болон одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Иргэний хууль дахь “Зээлийн гэрээгээр хүүг хэлэлцэн тохиролцож болно” гэж ерөнхий зохицуулсан зохицуулалтын аль аль нь ашгийн төлөө эсвэл ашгийн бус үйл ажиллагаа эсэхийг ялгах боломжгүй, ерөнхий зохицуулалт юм.

Аливаа ашгийн төлөө, тогтмол үйл ажиллагааг бүртгэлжүүлэн хянахын ач холбогдол нь эдгээр үйл ажиллагааны нөгөө талд үйлчилгээг нь хэрэглэж буй хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, тухайн бизнес хяналтгүйгээс болж мөнгө хүүлэлт, мөнгө угаалт бий болохоос сэргийлэх, татвар шударгаар төлөгдөх нөхцөлийг бүрдүүлдэг билээ.

Гадаад улсын зохицуулалтаас харахад, нийтлэг байдлаар мөнгөн зээлийн үйл ажиллагааг ашгийн төлөө, тогтмол эрхлэх бол бүртгэх, бүртгэлийн гэрчилгээ олгох, эсхүл тусгай зөвшөөрөл олгох, уг зээлийн үйл ажиллагаанд зээлийн хүүгийн дээд хэмжээ тогтоох, эрхлэгч нь орлогын албан татвар төлөх буюу энэхүү харилцаа нь бизнес эрхлэгч, хэрэглэгч нарын хооронд явагдах В2С харилцаа болохыг тогтмол бус, ашгийн төлөө бус зээлийн үйл ажиллагаанаас ялгаж байна.

Харин 2016 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл Үндсэн хуулийн холбогдох заалтыг

зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай 07 дугаар бүхий Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтэд зааснаар өмчлөгчийн эрхийг хамгаална, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй гэсэн Үндсэн хуулийн заалтыг “Зээлийн гэрээ нь хариу төлбөргүй байна” гэснээр иргэдийн хүү авах, ашиг олох эрхийг зөрчиж байгаа талаар дурдсан.

Гэвч зээлийн үйл ажиллагааг тогтмол, ашгийн төлөө явуулж тодорхой хүрээний хэрэглэгчтэй болж ашгийн төлөө мөнгөн зээлийн үйл ажиллагаа тогтмол эрхлэгч нарын хувьд бүртгэлжүүлэн хяналт тавих, улмаар тэдгээрийн үйлчилгээг авч буй зээлдэгч буюу хэрэглэгчийн эрхийг хамгаалах, үүнийг тогтмол бус, ашгийн бус байдлаар зээл олгох харилцаанаас ялгах нь Үндсэн хуулийн холбогдох зохицуулалтыг зөрчихгүй, суурь зарчмуудтай нь нийцэх болно.

Хэрэв энэ харилцааг ялгахгүй бол хэт ерөнхий заасан Иргэний хуулийн холбогдох зохицуулалтын хүрээнд иргэд ямар ч хяналтгүй өндөр хүүтэй зээл олгож, нөгөө талд зээлийг авч буй иргэд хэрэглэгчийн эрх зөрчигдөж, татвараа шударгаар төлөхгүй байх, мөнгө хүүлэх гол үндэс болж байна.

“Гэрээний талуудын чөлөөт байдал” -ын талаарх Иргэний хуулийн 189 дүгээр зүйлийн 189.2 дахь хэсэг дэх “Нийгэм, хувь хүний ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор зарим төрлийн гэрээг гагцхүү төрийн эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр байгуулж болно. Тусгай зөвшөөрөл олгох журмыг хуулиар тогтооно” гэж заасан тул Иргэний хуулийн уг суурь зарчмын дагуу зээлийн гэрээний хувьд ашгийн төлөө үйл ажиллагаа, ашгийн бус үйл ажиллагааг ялган зохицуулах, санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах, мөнгө хүүлэлтээс сэргийлэхийн тулд бүртгэл, тусгай зөвшөөрлийн үндсэн дээр ашгийн, тогтмол үйл ажиллагааг нь явуулах, бүртгэлгүй зээлийн гэрээ байгуулах бол ашгийн бус, тогтмол бус байх талаар ялган тусгах нь Иргэний хуулийн зарчимтай нийцэхээр байна.

Түүнчлэн Иргэний хуулийн 5 дугаар зүйлд заасан “Гэрээний талууд харилцан хүлээн зөвшөөрсөн тохиолдолд өмнө үйлчилж байсан хууль тогтоомжоос илүү тааламжтай нөхцөл олгож байгаа шинээр баталсан хууль тогтоомжийг хэрэглэж болно” гэх байдлаар буцаж үйлчлэх зарчмын дагуу хэрэв энэ харилцааг зохицуулсан хууль батлагдвал, уг хуулийн төсөл батлагдахаас өмнө байгуулсан гэрээний хувьд талууд харилцан зөвшөөрөөгүй бол тус хууль буцаж үйлчлэхгүй байхаар зохицуулах боломжтой байна.

Өдрийн зээлийн тухайд АНУ, Канад, Англи, Австрали зэрэг улсад мөн адил энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэгчийг бүртгэлжүүлэн, хянаж, зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоож, урьдчилан болон өдрийн хүү авахыг хориглож, анхны зээлээ төлж дууссаны дараа тодорхой хугацаанд дахин өдрийн зээл олгож болохгүй талаар, түүнчлэн тогтоосон хүүгээс хэтэрсэн хүү авсан болон бүртгэлгүйгээр өдрийн зээлийн үйл ажиллагааг явуулсан тохиолдолд торгох болон хорих төрлийн ял шийтгэл оногдуулахаар хатуу хуулийн хариуцлагатай байхаар хуульчилсан байна.

Харин манай улсын хувьд өдрийн зээл эрхлэгч нар бүртгэл, хяналтгүйгээр үйл ажиллагаа явуулж, асар өндөр өдрийн хүүтэй, хүүгээ өдөр өдөрт нь авдаг, алданги цагаар тооцдог, үндсэн төлбөрөө төлж чадахгүй бол дахин өдрийн зээл олгож өрийн сүлжээнд санхүүгийн хэрэглэгчийг оруулдаг, гол төлөв санхүүгийн боловсрол доогуур хүмүүс өртдөг, мөнгө хүүлэлт, дарамт шахалтын эх үндэс болсон байгааг нэн яаралтай бүртгэлжүүлэн хянах, хүүгийн хэмжээнд хязгаарлалт

тогтоож, өдрөөр, эсхүл урьдчилан хүү авахыг хориглох шаардлагатай гэж үзэж байна.

Судалгаанд хамрагдсан улсуудыг харьцуулан судалсны үндсэн дээр Монгол Улсын хувьд барьцаалан зээлдүүлэх болон иргэд хоорондын зээлийн үйл ажиллагааг зохицуулсан хуулийн төсөл боловсруулахад голлон анхаарах дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч болон барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа эрхлэгч нарыг бүртгэлжүүлэн хянах, бүртгэлгүйгээр тогтмол, ашиг олох зорилгоор үйл ажиллагаа явуулсан этгээдэд зөрчлийн хариуцлага хүлээлгэх;
2. Бүртгэлийг Санхүүгийн зохицуулах хороо болон орон нутгийн байгууллага хийх, хянах;
3. Бүртгүүлэх этгээд, түүний удирдлага, ажилтанд шаардлага тавьж, үйл ажиллагааг мэргэшсэн болгоход чиглэх;
4. Бүртгэлгүйгээр мөнгөн зээлийн үйл ажиллагаа явуулбал эсвэл бүртгэлтэй этгээд тогтоосон хүүгийн хэмжээнээс өндөр хүү авбал мөн хүү авах эрхээ алддаг байх;
5. Итгэлцлийн үндсэн дээр зээл олгох, хуульд заасан хэмжээнээс хэтрэхгүй хүү тогтоох боломжийг үлдээх, гэхдээ энэ үйл ажиллагааг ашгийн төлөө, тогтмол явуулахыг хориглох;
6. Өдрийн зээл эрхлэгч нарыг бүртгэлжүүлэх, зээлийн хүүгийн дээд хэмжээг нь тогтоох, өдөр өдрөөр хүүг авахыг нь хорих, алданги тооцохыг хориглох, зээлийн гэрээ хэрэгжсэнээс тодорхой хугацаа өнгөрөх хүртэл дахин өдрийн зээл олгохгүй байх, бүртгэлгүй эрхэлбэл, түүнчлэн өндөр хүү тогтоовол мөнгө хүүлэх эрүүгийн хэрэг болгон хуульчлах;
7. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч нь анз, алданги авахыг хориглох;
8. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч нь бүртгэлд бүртгэгдсэн байршилдаа үйл ажиллагаагаа явуулах, өөр газар үйл ажиллагаа явуулахыг хориглох, хаах, байршлаа солих, шинэ салбар нээх бүрт бүртгэсэн байгууллагад мэдэгдэж зөвшөөрөл авах;
9. Их хувьцаа эзэмшигчид тавигдах шаардлагыг хуульчлах, их хувьцаа эзэмшигчийн талаар мэдээлэх үүргийг мөн хуульчлах;
10. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчид тавигдах шаардлага, хүлээх үүргүүдийг нарийн хуульчлах, зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх, бүртгэлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох үндэслэлийг хуульчлах;

11. Барьцааны хугацаа богино байх тул барьцааны хугацаа болон түүнийг сунгах үндэслэлийг хуульд заах;
12. Барьцаанд эд зүйл тавихад үнэлгээ хийх, үнэлгээ хийгээгүй бол гэрээ хүчингүй байх, барьцаанд тавьсан эд зүйлийг зарж борлуулснаас зөрүү орлогыг зээлдэгчид буцаан олгох талаар хуульчлах; ченж нарт шууд бага үнээр худалдаалдагийг хориглох;
13. Барьцааны гэрээ болон эд зүйлийн бүртгэлийн дэвтэр болон цахим бүртгэл бүртгэх;
14. Цагдаагийн байгууллага хулгайд алдагдсан эд зүйлийн талаар барьцаалан зээлдэгчид мэдэгддэг байх, сэжитэй эд зүйл барьцаалуулахаар ирсэн тохиолдолд барьцаалан зээлдүүлэгч цагдаагийн байгууллагад мэдэгддэг байх;
15. Зээлийн үйл ажиллагаанаас өөр үйл ажиллагаа эрхлэхийг хориглох;
16. Зээлийн үйл ажиллагаа явуулах байршилд ил харагдах газар бүртгэлийн гэрчилгээ, зээлийн хүүгийн дээд хэмжээ, нэмэгдүүлсэн хүү байх бол хэмжээний талаар байршуулах;
17. Зээлийн гэрээ болон бүртгэлийг хадгалах, эрх бүхий албан тушаалтан үзэж шалгах эрхтэй байх;
18. Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах үүднээс иргэдэд санхүүгийн боловсрол олгох, бичил санхүүгийн зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоох, үйл ажиллагааны дүрэм, журам батлах эрх бүхий Зөвлөлийг Санхүүгийн зохицуулах хорооны дэргэд байгуулах.